

20. Tessman, B. and Wolfe, W. 2011. Great Powers and Strategic Hedging: The Case of Chinese Energy Security Strategy. International Studies Review, 13(2), 214–40
21. Thoughts on the third neighbor policy <http://www.miliatematters.com/1/post/2012/07/thoughts-on-the-third-neighbor-policy.html> 07/26/2012
22. Wang Dong, Hedging in International Relations : The Cases of Asia Pacific States. 08/05/2015 https://d3qi0qp55mx5f5.cloudfront.net/cpost/i/content/Wang_Dong_Hedging_in_IR.pdf

ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДЛЫГ ТӨРИЙН БОДЛОГОД ТУСГАХ НЬ

М.Багбаатар

Социологи, нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

- **Асуудлыг дэвшүүлэхүй**

Социализмын дараах нээлттэй, зах зээлийн нийгэмд амьдарч буй хүмүүсийн орчин нөхцөл, ахуй амьдрал, харилцаа хандлага, оршин ахуйн үнэлгээ болоод тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үлэмж өөрчлөгдлөө. Энэхүү өөрчлөлт хувь хүнээсгэр бүлд, бүлгээс нийтлэгт, цаашилбал, нийгмээсбайгальорчныг хамран өргөн цар хүрээтэй явагдаж байна. Чухамдаа эдгээр өөрчлөлт, ахиц дэвшлийг нэгтгэн харуулах, хөгжил дэвшлийг тайлбарлах түлхүүр ойлголтын нэг бол амьдралын чанар юм. Орчин үедүлс орнууд нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшингээхүн амын амьдралын чанарын өсөлтөөр илэрхийлэх болсон. Амьдралын чанар нь объектив нөхцлийн хувьд хүн хэрэгцээгээ хангах, эрүүл, аюул түгшүүргүй амьдрах, субъектив хандлагын үүднээс хүмүүсийн аз жаргал, сэтгэл ханамжит байдлын чухал учир шалтгаан болох аж. Чухамдаа тухайн улс орны ард иргэдийн аюулгүй баталгаат байдал, нийгэм ахуйн хангамж, хэрэгцээ, хэрэглээний түвшин, сэтгэл ханамж, үнэлэмжээс өнөөгийн нийгмийн хөгжлийн төлөв байдал бүхэлдээ хамаарч байна.

Эдүгээ амьдралын чанарын судалгааны хүрээнд нийтийн сайн сайхан байдал, нийгмийн чанар(social quality), хүний болон орчны аюулгүй байдал, нийгмийн халамж, хамгааллын индекс, үндэстний аз жаргалын индекс зэрэг судалгааны шинэ тутам салбар, чиглэлүүд хөгжиж байна. Амьдралын чанарын үзүүлэлт дэлхийн улс орнууд, бүс нутаг, газарзүйн байршил, хүн амын онцлог, шилжилтийн дараах улс орнуудын нийгмийн өөрчлөлт, хөгжлийг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэх болов. Амьдралын чанар бол улс үндэстний хөгжлийн илэрхийлэл болохын зэрэгцээ улс орнуудын хөгжлийн түвшинг харьцуулах нэгэн чухал үзүүлэлт, үзэл баримтлал болжээ. Хөгжиж буй улс орнууд хүн амын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, цэвэр усны хангамж зэрэг материаллаг хэрэгцээ хангамжийг авч үздэг бол хөгжингүй улс орнуудад ард иргэдийн аюулгүй, амгалан тайван амьдрал, сайн сайхан байдал, нийгмийн чанар чухалд тооцогдох боллоо. Үүнтэй уялдан хүн амын амьдралын чанар хэрхэн өөрчлөгдөж байгааг, нийгмийн амьдралд гарч буй макро болон микро түвшний өөрчлөлттэй холбон судлах зайлшгүй шаардлага бий. Учир нь өнөөгийн хүн амын ядуурал, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт хийгээд бууралт, нийгмийн ахиц дэвшил болоод ухралт, хөгжлийн тулгамдсан асуудал болоод бодлогын шийдвэрбүхэн хүний амьдралын чанартай ямарваа нэгэн учгаар холбогдсон байдаг.

Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн хандлагад татагдан орсноор хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурал, эмзэг байдлыг бууруулах чиглэлээр хөгжлийн хувьд ойролцоо улс орнууд, түүнчлэн дэлхийн бусад хөгжингүй улс орнуудын туршлагыг нэвтрүүлэн, хөгжиж байна. Азийн улс орнуудын дотор ардчилал, зах зээлд шилжсэн туршлагаар дэлхий нийтэд

үлгэр жишээ болсон Монгол орны хувьд хүн амын амьдралын чанар шилжилтийн он жилүүдэд хэрхэн өөрчлөгдсөн, эдүгээ чухам ямар хэмжээнд байна, шилжилтийн болон дэлхийн улс орнуудтай харьцуулахад ямар түвшинд байгааг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үлэмж их.

Орчин үед улс орнуудын хөгжлийн түвшинг хүний хөгжлийн индекс болон Мянганы хөгжлийн зорилтын үр дүнгийн багц шалгуур үзүүлэлтээр тодорхойлж буй ч, эдгээр нь хүний амьдралыг бодитой, бүрэн гүйцэд илэрхийлээгүй, нийгэм, орчны сайн сайхан байдлын үзүүлэлтийг орхигдуулсан зэргээрээ шүүмжлэгддэг бол харин амьдралын чанарын үзэл баримтлалд эдгээрийг бүхэлд нь цогц хэлбэрээр, харилцан уялдаатай авч үзсэнээрээ онцлог. Хүний хөгжлийн үзүүлэлтэд одоогийн амьдралын нөхцөл ба тэрхүү нөхцөл байдлын талаарх хүний сэтгэл ханамж болоод үнэлгээ орхигдсон. Гэтэл угтаа хүн бол зөвхөн хөгжиж буй субъект бус, хөгжүүлэх ёстой объект ч бус, амьдралын олон талт хүчин зүйлсээс шалтгаалцан оршиж буй объект хийгээд үйлдэн амьдарч буй субъектийн аль алин нь мөн болно.

Тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур багана болох эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин зэрэг гурван нийтлэг хэмжүүрийг уялдуулан тэнцвэржүүлэхэд даян дэлхийн 21-р зууны хөтөлбөрийн зорилго чиглэх болсон эрин үед чухамдаа хүний сайн сайхан байдал, амьдралын чанарыг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хүрээнд хангах явдал хойшлуулшгүй чухлаар тавигдаж байна. Учрыг өгүүлвэл, 1) хөгжингүй орнуудын хувьд ядуурлыг эдийн засгийн өсөлтөөр бууруулах оролдлого эдүгээ бүтэлгүй болсон төдийгүй эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох баялгийн өсөлт, бараа бүтээгдэхүүний үйлчилгээний хүртээмж зэргээс үл хамаарч хүний амьдралын чанар доройтох хандлага ажиглагдсаар байгаа, 2) хүрээлэгч орчин тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур болохыг нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа боловч экосистемийн тэнцвэрийн алдагдал улс орнуудад нүүрлэж, энэхүү нөхцөл уул уурхай олборлолт давамгайлж буй улс оронд улам бүр эмзэг болж байгаа, 3) нийгмийн хөгжилд ардчилал, зах зээлд шилжих үйл явц онцгой нөлөө үзүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүмүүсийн оролцоо илт нэмэгдсэн ч, нөгөө талаас нийгмийн орчны хувьд гэмт хэрэг, түгшүүрт байдал илт өсөж, байгалийн орчны хувьд хүний амьдрах орон зай бохирдож, орчны тэнцвэр алдагдаж буй дүр зураг харагдаж байна.

• **Амьдралын чанарыг хэмжиж буй олон улсын шалгуур үзүүлэлтэд түлгүүрлан хүн амын амьдралын чанарыг хэмжих нь**

Олон улсад амьдралын чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтийг харилцан адилгүй томъёолсон байдаг. Хүний амьдралын чанар, сайн сайхан байдлыг илэрхийлэх нэгэн түгээмэл хандлага бол нийгэм, соёл болон байгаль, техникийн хүрээлэн буй орчинтой холбон үзэх явдал мөн. Эл хандлага хүний амьдралын чанарт нөлөөлж буй ерөнхий хүчин зүйлсийг гол болгож үздэг. Хүн биологийн организм болох хувьдаа амьдралын чанар, нөхцөл оршихуйн хувьд байгалийн хүчин зүйлсээс ихээхэн хамаарна. Философич Б. Даш-Ёндонгийн өгүүлснээр¹⁰⁶ хүний амьдрах орчинг бүрдүүлэх олон хүчин зүйл байх боловч хүний орших, эс оршихыг шийдвэрлэх хамгийн анхдагч бөгөөд эцсийн нөхцөл бол хүрээлэн буй байгаль орчин, уур амьсгал мөн. Хүрээлэн буй орчин, био-экологи, экосистемийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох агаар, ус, хөрсний гол хэрэглэгч нь “хүн” байдаг тул эдгээрээс хүний амьдралын чанар шууд хамаардаг нөгөө талаар харилцан шүтэлцээтэй.

Хүний амьдралын нөхцөл, чанарт био экологийн хүчин зүйлсээс дутуугүй нөлөө үзүүлэгч хүчин зүйл бол түүнийг хүрээлэгч социо-экологи юм. Энэ тухай эрдэмтэд “чухамдаа бүл, нийтлэгээс хамааран амьдарч буй шинж¹⁰⁷”, “жинхэнэ утгаараа нийгмийн харилцааны цогц¹⁰⁸” болох тэрхүү шинж хүнийг хүн болгодог” хэмээн үзжээ.

Хүний амьдралын чанарыг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг бол соёлын хүчин зүйлс болно. Социологич Г.В.Осиповын тэмдэглэсэнээр¹⁰⁹ нийгэмд өрнөж буй олон төрлийн харилцаа нь

¹⁰⁶Б. Даш-Ёндон. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013

¹⁰⁷Смелзер. Н. Социологи. Улаанбаатар: Адмон хэвлэл. УБ., 2000

¹⁰⁸Маркс. К., Энгельс. Ф. Түүвэр зохиол, 3 боть. Улаанбаатар. УХГ. УБ., 1982

¹⁰⁹Осипов. Г. В. Социология и социализм. М: Наука. 1990

явцуу утгаараа хүний амьдралын орчил, чанарыг илэрхийлэх соёлын хүчин зүйлс мөн. Техникийн дэвшил, ололт амжилтууд хүний амьдралын чанарыг илэрхийлэх нэгэн макро орчил болох бөгөөд зарим тохиолдолд соёлын хүчин зүйлтэй давхцах, уялдахыг үгүйсгэхгүй. Тухайлбал, өнөөгийн хүн төрөлхтний хэрэглэж буй “гар утас” бол нэг талаас соёлын нөгөө талаас техникийн ололт бөгөөд нэгэн зэрэг хүмүүстэй харилцах, цаг баримжаалах, зурагт, радио орлох, цахим шуудангаа шалгах, цаг агаарын болон бусад өдөр тутмын мэдээлэл авах, тооцоолол хийх зэрэг олон тооны харилцан үйлдлийг гүйцэтгэж баттай чадна. Энд дурдаж буй макро орчил бол улс орнуудын амьдралын чанарыг харьцуулах түгээмэл хүчин зүйлс бөгөөд тухайн улс орны хүмүүсийн оршин амьдарч буй хүрээлэн буй байгаль орчин, уур амьсгал(амьсгалж буй агаар, ууж буй ус, гишгэж буй хөрс гм М.Б), харилцан үйлдэж, төлөвшин хүмүүжиж буй нийгэм соёлын байдал, эзэмшиж буй техник хэрэгслийг бүхэлд нь агуулна.

Дэлхийн улс орнуудын амьдралын чанарыг хэмжихдээ а)улс орнуудыг харьцуулах бололцоотой(түгээмэл), б) тухайн улс орнуудын онцлогийг тусгасан(өвөрмөц), хүчин зүйлийг аль алиныг нь харгалзах явдал нэн чухал байна. Олон улсын түвшинд амьдралын чанарыг хэмжихдээ дараах үзүүлэлтийг шалгуур болгон авч үздэг. Үүнд:

- Эрүүл мэнд: Төрснөөс хойшхи амьдралын үргэлжлэх хугацаа-наслалт
- Гэр бүлийн амьдрал: 1000 хүн ам тутам дахь гэр бүл салалтын түвшин
- Олон нийтийн харилцаа: Холбоо харилцаа, нэгдэл, итгэлцэл
- Материаллаг сайн сайхан байдал: нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн , орлого зарлагын харьцаа
- Нийгмийн үйлчилгээ: Нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж
- Цаг агаар: газарзүйн нөхцөл байдал, улирлын халуун хүйтэн
- Ажил эрхлэлт: Ажилгүйдлийн түвшин
- Улс төрийн эрх чөлөө: Улс төр, иргэний эрх чөлөө
- Хүйсийн эрх тэгш байдал:эргэтэй эмэгтэйчүүдийн дундаж цалин хөлс

Эдгээр үзүүлэлтийг авч үзэхэд ихэнх нь макро түвшний үзүүлэлт байгаа нь санамсаргүй хэрэг биш юм. Учир нь энд амьдралын чанарыг хэмжих үзүүлэлтүүд хэт ерөнхий бөгөөд улс орнуудын нийгмийн хөгжлийг харьцуулах зорилгоор хийгдсэн байна. Статистик, суурь судалгаа, бүртгэл мэдээлэл өндөр хөгжсөн улс орнуудад эдгээр үзүүлэлтийг ашиглан амьдралын чанарыг хэмжих бололцоотой. Ялангуяа өгүүлэн буй ангилал болоод үзүүлэлтүүд, “амьдралын чанар бол зөвхөн макро түвшний хүчин зүйл мөн” гэсэн дүгнэлтэд хараахан хүргэхгүй юм. Улс орон бүр амьдралын чанарыг хэмжих өвөрмөц аргачлалтайн зэрэгцээ тухайн аргачлалаар хийсэн үр дүнг бусад улс орнуудтай харьцуулан, өөрийн орны хөгжлийн түвшинг тодорхойлдог.

Амьдралын чанарын талаар Оросын эрдэмтэд олон тооны судалгаа хийсэн юм. Социалист нийгмийн үед хүмүүсийн амьдрал ахуйг “аж төрөх ёс” хэмээх ойлголтоор дамжуулж судалсан эрдэмтэд¹¹⁰ нийгэм, улс төрийн тогтолцооны өөрчлөлтөөс хойш “амьдралын чанар” хэмээх ойлголтыг олон талаас нь судалж ирсэн байна. Тус улсын хэмжээнд 2000 оноос хойш амьдралын чанарын сэдвээр дагнан 50 гаруй эрдэм шинжилгээний бүтээл туурвисан¹¹¹байна. Эдгээр бүтээлд тусгаснаар хүн амын орлого, хүн амын хэрэглээ ба зарлага, мөнгөн хадгаламж, хөрөнгийн хуримтлал, орон сууц, нийгмийн ялгарал, хангамж тааруу нийгмийн давхраа зэрэг нийтлэг шалгуур үзүүлэлтийг дурьдсан байна.

Тухайн үзүүлэлтүүд харьцангуй(тухайлбал, мөнгөн хадгаламж улс орон бүрт харилцан адилгүй хэмжээ ба үнэлгээтэй), хийсвэр(нийгмийн ялгарал гм үзүүлэлтийг хэмжихэд ихээхэн төвөгтэй бөгөөд түгээмэл биш) шинжтэй бөгөөд бусад улс орнуудтай харьцуулахад

¹¹⁰Бестужев-Лада.И.В. Методологические проблемы исследования качества, уровня и образа жизни. Москва: ИСИ АН., 1978 Давыдова.Е.В.,Давыдов А.А.(1993).Измерениякачестважизни. М.Наука., 1993.Бобкова.В. Качество и уровень жизни населения в новой России (1991-2006 гг.). Москва: ВЦУЖ 2007

¹¹¹Энэ тухай www.dissercat.com цахим хуудаснаас дэлгэрүүлэн үзнэ үү.

хүндрэлтэй юм. Нөгөөтэйгүүр эл чиглэлийн судалгаанууд амьдралын чанарын бүс нутгийн ялгааг харуулах, нийгэм эдийн засгийн ойлголт болох хувьд нь тодорхойлох, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого, удирдлагад ашиглах¹¹² зэрэгт чиглэсэн байна. Өгүүлснийг хураангуйлан үзвэл, тухайн улсад хийгдсэн амьдралын чанарын судалгаа эрэл хайгуулын түвшинд, нэг мөр болж цэгцрээгүй байгаа болно. Харин манай урд хөрш Хятад улсын хувьд өрнөдийн болон америкийн боловсролын тогтолцоог дорнодын сургах зүйн онцлогтой уялдуулж, нийгмийн үйл явцтай танилцсанаар орчин үеийн нийгмийн хөгжлийн үзэл баримтлал болох нийгмийн чанар, аюулгүй байдал, үндэсний аз жаргал зэргийг олон талаас нь эрчимтэй судалж эхэлж байна. Үүний тодхон жишээ бол тус улсын хувьд 2010 оноос хойш “Үндэстний нийт аз жаргал”[Gross National Happiness] гэсэн хэмжүүрээр хөгжлөө тодорхойлж¹¹³ эхэлсэн явдал юм. Хятад улсын хувьд амьдралын чанарын судалгаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд ард иргэдийнхээ амьдралын төвшинг дээшлүүлж, аз жаргалтай байлгахад үндэсний нийт бүтээгдхүүний тасралтгүй өсөлтийг харгалзан үзэх төдийгүй ард иргэдийн амьдралын чанартай шууд холбогдох эмчилгээ, боловсрол, орон сууц зэрэг хүчин зүйлсийг ч чухалчлах хэрэгтэй гэж үзсэн. Олон улсын цөөнгүй байгууллага, сэтгүүлд амьдралын чанарын индексийг тооцоолж үзсэн(NEF, Economist, International living гм) ба тэдгээрт Монголчуудын амьдралын чанарын талаарх бүрэн гүйцэд мэдээлэл байхгүй. Судалгааны баримтаас үзэхэд “Олон улсын амьдрал”сэтгүүлд амьдралын чанарын индексийг Амьдралын өртөг(15%), Соёл урлаг, чөлөөт цаг(10%), Эдийн засаг(15%), Дэд бүтэц(10%), Эрх чөлөө, ардчилал(10%), Эрүүл мэнд(10%), Эрсдэл болон аюулгүй байдал(10%), Цаг агаар(10%), Хүрээлэн буй орчин(10%) зэрэг үзүүлэлтээр хэмжсэн байна. Дээрх үзүүлэлтэд тулгуурлан Монгол Улсын 2005-2008 оны амьдралын чанарыг тухайн байгууллага барагцаалан тооцоолж дараах үр дүнг мэдээлсэн.

Хүснэгт 1. Монгол Улсын амьдралын чанарын индекс/2005-2008/

Хэмжсэн үзүүлэлт	2005	2006	2007	2008
Амьдралын өртөг	70	78	86	63
Соёл урлаг, чөлөөт цаг	52	65	67	63
Эдийн засаг	32	43	39	35
Хүрээлэн буй орчин	70	72	77	70
Эрх чөлөө, ардчилал	83	83	83	83
Эрүүл мэнд	42	55	58	58
Дэд бүтэц	40	41	34	50
Эрсдэл болон аюулгүй байдал	50	50	64	64
Цаг агаар	14	1	7	14
Амьдралын чанарын индексийн дундаж	50.3	54.2	57.2	55.6
Эзлэх байр	120	114	108	100

Монголчуудын амьдралын чанарыг индекс хэлбэрээр илэрхийлсэн энэхүү дүнгээс харахад эрх чөлөө, ардчилал гэсэн нийгэм, улс төрийн үзүүлэлт харьцангуй тогтвортой, өндөр үнэлгээтэй, нөгөө талаас шилжилтийн дараах улс орнуудтай харьцуулахад дундаж үзүүлэлттэй байна.

Түүнчлэн манай улсын хувьд амьдралын өртөг, хүрээлэн буй орчин зэрэг үзүүлэлт харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан нь сонирхол татаж байна. Бодит байдалд амьдрах өртөг зардал сараар биш өдрөөр өсөж, азийн болон дэлхийн улс орнуудын дунд явуулсан харьцуулсан судалгаанаас хот орчмын агаарын бохирдлоор дээгүүрт ордог(2-оос 10-р байрт)байна. Соёл урлаг, чөлөөт цаг, эрсдэл болон аюулгүй байдал, эрүүл мэнд зэрэг үзүүлэлт дундаж үнэлгээтэй гарсан бол, эдийн засаг, дэд бүтэц зэрэг үзүүлэлт багавтар, цаг агаар хамгийн бага үнэлгээ авсан байна. Эрс тэс уур амьсгал, өвөл зуны температурын зөрөө их (-40⁰C-ээс +40⁰C), 10 жил


¹¹²(<http://mongolian.ruvr.ru>)ОХУ-ын төлөөлөгч Н.Раковский амьдралын чанарын гол үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх улс орон болох зорилготой хэмээн НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хэлсэн үг.

¹¹³<http://mongol.cri.cn/343/2011/03/04/61s150656.htm>.Хятадын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Зябаогийн илтгэл.

тутмын давтамжтай зуд турхан зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд энэхүү үнэлгээнд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Дээрх мэдээлэлд тулгуурлан шилжилтийн эдийн засагтай улс орнуудын амьдралын чанартай харьцуулан үзвэл, Монгол Улс 26 орноос 55.6 гэсэн үнэлгээгээр 15-р байранд орсон нь дунджаас доогуур түвшинд байгааг харуулах боловч эдгээр мэдээллийг ямар эх сурвалжаас авч ашигласан нь тодорхой бус аж. Тухайн аргачлалаар явуулсан хэд хэдэн судалгаанд Монголчуудын амьдралын чанарыг хэмжих оролдлого хийсэнбөгөөд статистик мэдээллийн хувьд учир дутагдалтай байна. Тухайлбал, а) энэ чиглэлийн статистик болон бүртгэл судалгаа дутмаг, б) тухайн хэмжих үзүүлэлтийг харьцуулан нэгтгэхдээ хүний хөгжлийн нийтлэг индексийг гол шалгуур болгосон байна. Дээрх сэтгүүлд дурьдсанаар Монгол Улс амьдралын чанарын түвшингээр харьцуулсан 198 орноос 2006 онд 114-т, 2007 онд 108-д, 2008 онд 100-р байранд тус тус орж байжээ. Өгүүлэн буй үзүүлэлтээс харахад Монголчуудын амьдралын чанар бусад улс оронтой харьцуулахад байр ахих эерэг хандлагатай байна. Дэлхийн улс орнууд(Тухайлбал, Европ болон Скандинавын орнууд) иргэдийнхээ амьдралын чанарыг хэмжин тогтоох судалгааг 1960-аад оноос эхлэн явуулж эхэлсэн түүхтэй юм. Тухайн орны засгийн газар жил бүр иргэдийнхээ амьдралын чанарыг хувь хүний сайн сайхан байдал, эдийн засаг, нийгмийн зонхилох шалгуур үзүүлэлтээр тодорхойлдог байна.

Хөгжингүй улс орнуудад амьдралын чанарын талаар олон тооны нийгмийн шалгуур үзүүлэлт гаргасан байдаг. Тухайлбал, НҮБ-аас 12 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон¹¹⁴ ба үүнд хүн амын эрүүл мэндийн хамгаалал, ахуйн нөхцөл, хүмүүжил, хөдөлмөрийн нөхцөл, хүн амын ажил эрхлэлтийн байдал, хэрэгцээ ба нөөц, тээвэр ба харилцаа холбоо, амьжиргааны байдал, барилгажилт, хувцасхунар, амралт зугаа цэнгэл, нийгмийн итгэлцэл, хувийн эрх чөлөө гм-ийг хамарсан байна. Дээр дурьдсан амьдралын чанарыг хэмжих оролдлого болон загваруудад тусгагдсан амьдралын чанарын салшгүй шинжүүд болон бүрдүүлэгч хүчин зүйлсийг харгалзан үндэсний түвшинд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж болно.

Зураг. 1 Амьдралын чанарыг хэмжихэд харгалзах үзүүлэлт



Чухамдаа улс орнуудад өргөнөөр хэрэглэж буй дээр дурьдсан амьдралын чанарыг бүрдүүлэгч шинжийг харгалзан, Монголчуудын амьдралын чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтийг уур

¹¹⁴UNO. International definition and measurement of standards and levels of living, NY., 1961

амьсгал, улс орны нөхцөл, амьдралын хэв маягийн онцлог, соёл уламжлалд тулгуурлан шинээр тодорхойлж болох юм. Судалгааны үр дүнгийн тооцооллоос үзэхэд өнөөгийн(2015-2016 он) Монголчуудын амьдралын чанарын индекс дундаж түвшнээс багахан дээгүүр буюу 3.52 буюу 10 хүртэлх баллаар тооцож үзэхэд 7.04 гэсэн үзүүлэлттэй байна. Үүнд тулгуурлан Монголчуудын амьдралын чанарын индексийг тооцоолж үзвэл дунджаас үл ялиг дээгүүр түвшинд байна.

Зураг 2. Амьдралын чанарын индекс[10 хүртэлх оноогоор тооцсон үнэлгээ]



Монголчуудын амьдралын чанарын индексийг тухайн шалгуур үзүүлэлтээс гадна олон улсын түгээмэл аргачлал болох 9 үндсэн шалгуур бүхий олон улсын аргачлалд тулгуурлан тооцож үзэхэд 3.42 дундаж үнэлгээтэй байна. Үүнийг 10 хүртлэх баллаар тооцвол 6.84 буюу шинээр боловсруулсан шалгуураас 0.20 пунктээр бага байна. Олон улсын аргачлалд материаллаг нөхцөл, амьдралын өртөг болон эдийн засгийн үзүүлэлтийг гол болгосон, нөгөө талаар сэтгэл ханамжийг тооцоогүй байдал энэхүү үнэлгээний үр дүн зөрүүтэй гарахад нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Нөгөөтэйгүүр Монгол хүний өнөөг биш маргаашийг хардаг уужуу тайван, хүлээцтэй байдал, итгэл үнэмшил, сэтгэл ханамжийн хүчин зүйлс үүнд нөлөөлсөн байж мэднэ. Олон улсын аргачлалд тулгуурлан тооцсон үр дүнгээр Монголчуудын амьдралын чанарыг дэлхийн улс орнуудтай харьцуулан үзэхэд 105-р байранд, шилжилтийн улс орнуудтай харьцуулахад 11-рт тус тус эрэмбэлэгдэж байна. Тухайн хэмжилтэд тулгуурлан Монгол Улсын хүн амын бүлгүүдийн амьдралын чанарт тулгамдаж буй зарим асуудлыг тайлбарласан болно.

Хүүхэд, залуучуудын амьдралын чанар. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад сөрөг үзэгдэлд хамгийн их өртсөн бүлэг бол хүүхэд, залуучууд юм. “Хүүхэд нас, бие бялдар, сэтгэц, сэтгэл зүйн онцлогоос хамааран өөрийгөө хамгаалах чадвар, чадамж нь хязгаарлагдмал, өөрөө бусдаас тусламж хүсч чаддаггүй, насанд хүрэгчдээс хамааралтай” байдаг тул аливаа сөрөг үзэгдэлд өртөмтгий байдаг ажээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3-р зүйлд зааснаар¹¹⁵ “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаална” гэжээ. Тэрчлэн тухай хуулийн 5.2-д “Хүүхэд эрүүл мэнд өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх, цаашилбал хувцас, хоол хүнс, орон байраар гачигдах ёсгүй” хэмээн амьдралын чанарын бүрдэл хэсгүүдийг зааж өгсөн байна. Нийгэмд, ялангуяа зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд ядуурал, гэмт хэргийн өсөлт, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл нэмэгдэхэд ажилгүйдэл голлох нөлөө үзүүлдэг байна. Хүүхэд залуучуудын амьдралын чанарын тухай авч үзэж, тодорхойлохын тулд тэдгээрийн эрх, оролцоо, сайн сайхан байдлыг авч үзэх шаардлагатай. Судалгааны анхаарлын төвд Монголчуудын амьдралын чанарын асуудалд чиглэж буй тул Монгол дахь бүхий л нөхцөл байдал гэхээсээ, өнөөгийн хүүхэд залууст тулгамдаж буй цөөн хэдэн асуудлаар хязгаарлав. “Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” үндэсний илтгэлд¹¹⁶ дурьдсанаар хотын залуусыг хөдөөгийн залуустай харьцуулахад ажиллах

¹¹⁵УИХ. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. 3-р зүйл. УБ. 1996, 2015.

¹¹⁶“Монголын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал” Үндэсний илтгэл. УБ., 2006.

хүчний оролцооны түвшин ихээхэн доогуур байна. “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлангаас¹¹⁷ тооцож үзэхэд судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 24,3-37,3%, эмэгтэйчүүдийн 18,5-20,6% нь мэргэжилгүй хүмүүс байсан. Ажилгүйдэлд залуус илүү өртөмтгий хэвээр байна. Тухайлбал, Үндэсний статистикийн газраас Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр 2002-2003 онд анх удаа явуулсан ажиллах хүчний суурь судалгааны¹¹⁸ дүнгээс үзэхэд залуучуудын ажилгүйдлийн түвшин хүн амын бусад насны бүлгийнхэнтэй харьцуулбал өндөр байна. Эрүүл мэндийн статистик судалгаагаар өсвөр насныхны 7 хувь нь хоол тэжээлийн асуудалтай, 16 хувь нь бие бялдрын хоцрогдолтой, 25 хувь нь цус багадалттай, 26 хувь нь ганцаардал, сэтгэл гутралтай, гурван хүүхдийн нэг нь иод дутагдалтай гэж гарчээ. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрөөс үзэхэд ядуу буюу орлого багатай хүн ам, тухайлбал залуучууд бусад бүлгийн хүмүүсийг бодвол эрүүл мэндийн салбарын үйлчилгээг бага хүртдэг байдал харагдаж байна. Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн боловсролын салбарт хүндрэл учруулж, хот суурин газрын сургуулийн ачаалал хэд дахин нэмэгдсэн бол хөдөөгийн сургуульд суралцагчдын тоо буурч, хөрөнгө оруулалт болон ашиглалт буурсан дүн¹¹⁹ бий. Түүнчлэн хөдөө орон нутагт сургууль завсардалт өндөр, сургуулийн хүртээмж хангалтгүй, дотуур байрны зардал их, хүрэлцээ муутай байгаа нь хүүхэд айлд тусгаарлагдах, хүчирхийлэлд өртөх, тусдаа гэрт амьдрах зэргээр амьдрах орчны аюулгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдлууд байна.

Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхдүүдийн дунд амиа хорлох оролдлого ихээр гарах болсны нэг илрэл гэвэл Хордлого тайлах төвд жилд дунджаар 200 орчим хүүхэд дээрх шалтгаанаар ирдэг байна. Уул уурхайн олборлолт бүхий, хөл хөдөлгөөн ихтэй орон нутгийн Залуусын дунд сүүлийн үед хар тамхи хэрэглэх, мансуурах явдал ихсэх төлөвтэй байна. МУЗГ-ын 5 дугаар тогтоолоор “Биеийн тамир- эрүүл мэнд” уриан дор “Өсвөр үеийнхэн залууст ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г санаачлан НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ-ын мэргэжил арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр залууст ээлтэй үйлчилгээ үзүүлэх клиникүүдийг байгуулсан байна. Гэвч эдгээр үйл ажиллагаа төслийн хэмжээнд хэрэгжиж дууссан бөгөөд цаашид төр засгийн зүгээс урт хугацаанд бодлого болгон хэрэгжүүлэх нь чухал юм.

Хүүхэд зөвхөн гадна орчноос, үе тэнгийнхний зүгээс, эсвэл сургууль болон гудамж талбайд хүчирхийлэлд өртөх гэхээсээ өөрийн өрх гэртээ дарамт хүчирхийлэлд өртөх явдал ч түгээмэл байна. Статистикийн албан мэдээллээс үзэхэд судалгаанд хамрагдсан 2-14 насны хүүхдийн 4 хувь нь ямар нэг байдлаар аав, ээжийн зүгээс сэтгэл санааны дарамт болон бие махбодийн шийтгэлд өртсөн байна. Энэ талаар Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээг үнэлэх зорилгоор ЯХИС-ийн дэмжлэгтэйгээр хийсэн судалгааны үр дүн¹²⁰-гээс эрэмбэлэн эхний таван хүчин зүйлийг түүвэрлэн, сонирхуулж болох байна.

Хүснэгт 2. Хүүхэдтэй зүйл бусаар харьцаж буй хэлбэрүүд/хүүхдийн сонголтоор/

Хариулт	Хувь	Эрэмбэ
Сэтгэл зүйн хувьд доромжлох, гүтгэх, айлгах, сүрдүүлэх зэргээр хэрцгий хандах, хүчирхийлэх, дарамтлах	57.0	I
Бие махбодын хувьд өвтгөх, зодох зэргээр хэрцгий хандах, хүчирхийлэх, дарамтлах	54.4	II
Буруу зан үйлд уруу татах (тамхи татах, янз бүрийн мансууруулах бодис үнэртэх, архи уулгах г.м)	14.9	III
Сургуульд сурахаас татгалзуулах, эрүүл мэндийн үйлчилгээ авахуулахгүй байх	9.6	IV

¹¹⁷МУЗГ. НХХЯ. “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлан УБ., 2007.

¹¹⁸Үндэсний статистикийн газар, Азийн хөгжлийн банк: Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, УБ., 2004.

¹¹⁹М.Батбаатар болон бусад. Хот хөдөөгийн шилжих хөдөлгөөн ба хүүхдийн боловсролын хүртээмж. АХИС, ХЯБСТ. УБ., 2005.

¹²⁰Г.Түмэннаст болон бусад. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээний өнөөгийн байдал. ЯХИС.УБ., 2015.

Өлсөх, цангах, даарах нөхцөлд амьдруулах, орхих, анхаарал тавихгүй байх	7.9	V
---	-----	---

Энд дурьдсан хүчин зүйлс олон сонголтоос эрэмбэлсэн тул нийлбэр нь 100 хувьтай тэнцэхгүй. Үүнээс гадна хүүхдэд хурдан морь хүчээр унуулах(7.9) эмзэг эрхтэн, биед нь хүрэх, илэх, бэлгийн ажил хийхээр завдах, халдах, уруу татах(6.1), хүүхдийг гэмт хэрэгт уруу татах, түлхэх, ашиглах(6.1), хүчээр ажиллуулах, зарцлах, гуйлга гуйлгуулах зэргээр мөлжих(7.0), асран хамгаалалтгүй, хайр халамжгүй орхих(4.4), санаатай болон санамсаргүйгээр бие махбод, сэтгэл санааны дарамтад оруулах эрсдлийг бий болгох(3.5), хүүхэд хүүхдээ дээрэлхэх, дарамтлах (3.5) зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд байсаар байна. Иймэрхүү байдлаар хүчирхийлэл дарамтад өртсөн тохиолдолд хүүхэд хэнд хандахаа мэдэхгүй, тохиолдсон дарамт бэрхшээлийг ихэвчлэн эцэг эхтэйгээ хуваалцах тухай илэрхийлсэнээс үзэхэд хэрэв дарамт хүчирхийллийн субъект эцэг эх байсан тохиолдолд шийдвэрлэх асуудал илүү бэрхшээлтэй болох ажээ.

Өнөөгийн хүүхдийн амьдралын чанарыг тодорхойлох орчин, нөхцөл хангалтгүй, хүүхдэд ээлтэй биш байгааг хүүхдийн хоёрдахь амьдрах орчин болсон өрх гэр, сургуулийн орчинд үйлдэгдэж буй эцэг эх, багш, үе тэнгийнхэний хүчирхийллээр тайлбарлаж болно.

Нийгмийг хөдөлгөгч томоохон бүлэг болохын хувьд залуучуудын амьдралын нөхцөл, хэрэгцээ хангалтын байдал болон сэтгэл ханамжийн хүчин зүйл судлаачдын анхаарлын төвд байдаг. Залуу нас бол амжилт бүтээл, алдаа оноо хосолсон хүний насны оргил үе юм. Тиймээс ч залуу насанд оргилуун хүсэл, өөдрөг үзэл, шинэ санаа, эрч хүч, эр зориг, эрмэлзэх тэмүүлэл, хурц тод мэдрэмж, авьяас билгийн асар их нөөц бийг нэрт судлаач Х.Гүндсамбуу¹²¹ тэмдэглэжээ. Чухамхүү эл насанд хүн бие, сэтгэхүйн хөгжил болон нийгэмшлийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцохын зэрэгцээ эрх эдлэн, үүрэг хүлээж, нэг ёсондоо эрх зүйн чадамж бүрдэж эхэлдэг. Дээрхийн хамт боловсрох, мэргэжил эзэмших, гэр бүлийн амьдрал шинээр зохиох, эцэг эхээсээ өрх тусгаарлах, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг олон асуудлууд тулгамдсан шинжтэй болж ирдэг¹²² байна. Олон улсын байгууллагуудын тодорхойлолт, стандартаар залуучуудын бүлэгт 16-30 хүртэлх насны хүмүүсийг хамруулж үзэх нь нийтлэг байна. Эл чиглэлээр хийсэн судалгаанаас үзэхэд¹²³ өнөөгийн залуусын амьдралын чанарт дараах асуудал, хүчин зүйлс нөлөөлж байна.

Залуучуудын талаар баримтлах төрийн бодлогын асуудлаар хийсэн судалгаанд дурьдсанаар дараах зүйлс баримтаар нотлогджээ.

- Залуучуудын гэр бүл төлөвлөлт хойшилж, гэрлэх нас оройтож байна.
- Залуучуудын гэрлэлтэд хариуцлагагүй, хайнга байдал давамгайлж байна.
- Өнөөгийн өрх бүлийг тойрсон асуудлууд залуу гэр бүлийн амьдралд сөргөөр нөлөөлж байна.
- Залуу гэр бүлд санхүүгийн асуудал тулгамдсан шинжтэй хэвээр байна.
- Монголын залуучууд эрүүл мэндийн хувьд баталгаагүй, хүнд, хортой, аюул осол өндөр нөхцөлд ажиллаж, амьдарч байна.
- Залуучуудын дунд стресс, бухимдлаас /үүдэлтэй зүрх судасны өвчин ихсэх хандлагатай байна.
- Залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх дадал хэв маягт зохисгүй хэлбэрүүд байсаар байна.
- Монголын залуучуудын нийгмийн хамгаалал, дэмжлэгт албан бус тогтолцоо болох эцэг эх үр хүүхдийн, үр хүүхэд хоорондын, садан төрлийн тусламж зонхилж байгаа болно.
- Залуус төрийн албан дэмжлэг тусалцаанаас хоцорч байна.
- Залуучуудын хувьд баталгаат бус ажил хөдөлмөр, үүнээс шалтгаалсан эмзэг байдал буурахгүй байна.
- Залуучууд чанаргүй боловсролд сэтгэл ханамжгүй байна.

¹²¹Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар. XXI зууны босгон дахь Монголын залуучууд.. Адмон хэвлэл. УБ., 2000.

¹²²М.Батбаатар. Залуучуудын амьдралын чанарт нөлөөлж буй нийгмийн асуудлууд: төлөв байдал, чиг хандлага. Нийгмийн ажил сэтгүүл. №4, X.9. МУИС.УБ., 2010.

¹²³НАМЗХ, Социологийн Боловсрол төв. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого суурь судалгааны урьдчилсан тайлан. УБ., 2013.

Тэрчлэн диссертацийн хүрээнд хийсэн амьдралын түүхийн судалгаанаас үзэхэд өнөөгийн залуу хүний нийгмийн зорилгод хүрэх арга хэрэглүүрийн хувьд эрс өөрчлөлт орж “зорилго нь аргаа зөвтгөх” үзэл хандлагатай, аль болох “бага хөдөлж, ихийг олох”, “өнгө, мөнгийг тэргүүнд тавих”, “хөдөлмөрийн үр шим бус, олж буй мөнгөний тоо хэмжээг гол болгох”, “бусдын бус амин хувийн эрх ашгийг дээдлэх” зэрэг нь өнөөгийн залуусын оюун сэтгэхүйн нийтлэг төлөвшил болж байна.

Дунд эргэм насны хүмүүсийн амьдралын чанар.31-45 хүртэлх нас бол уламжлалт хэлц үгээр “эрийн цээнд хүрч, чөмөг гүйцэх” ба амьдралын хувьд “амьдрал тогтож, бэл зузаарах” онцлог үе юм. Дунд эргэм насны хүмүүсийн амьдралын нөхцлийг хүүхэд залуус болон ахмад настнуудтай харьцуулахад орлого болон биет хөрөнгийн хувьд харьцангуй илүү байна. Эл насны бүлгийн хувьд байнгын ажил хөдөлмөр эрхэлж, орлого олж, хөрөнгө чинээтэй болж, амьдрах сууцаа шийдэхийн зэрэгцээ хүүхдийн сурч боловсрох асуудал тулгамдсан шинжтэй болж ирдэг. Статистик мэдээллээс үзэхэд 1989-2000 онд гэр бүлээ цуцлуулсан хүний тоо 2 дахин их нэмэгдсэн бөгөөд энэ байдал 30-44 насныхны дунд өндөр байна. Тухайн насны хүмүүсийн хариултаас үзэхэд гэр бүл салалтын шалтгааны 54.0 хувь нь итгэл алдарсан, 47.3 хувь нь санхүүгийн бэрхшээлтэй, 41.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөөс үүдсэн байна. Тухайн насны бүлгийн хүмүүсийн дунд стресс, бухимдал, дорой амьдралаас болж, сэтгэлээр унах, улмаар архинаас хамааралтай болох явдал ч цөөнгүй. Архи тамхийг их хэмжээгээр хэрэглэснээс элэгний хатуурал, хорт хавдар зэрэг өвчлөлд өртөх явдал энэ насны хүмүүсийн дунд ихэсч байна. Эрсдэл хийх, мөрийтэй тоглоом тоглох, улмаар хамааралтай болох зэрэг нь энэ насныханд тохиолдож буй нийтлэг хандлага болж байна.Товчхон дүгнэхэд энэ насанд амьдрал төвхнөөгүй бол ирээдүйдээ итгэх итгэл найдвар байхгүй болж, улмаар үе дамжсан ядуурлын эхлэл тавигдах нөхцөл бүрддэг байна. Дунд эргэм насны хүмүүсийн дийлэнхи олонхи нь төр, төсвийн байгууллага болон албан бус сектор, бизнесийн салбарт ажиллаж байна. Төрийн тогтворгүй байдлаас хамаарч ажлаас халагдах, цалин орлого тогтворгүй болох, улирлын чанартай ажил хөдөлмөр эрхлэх, ажилгүй болох зэрэг олон тооны эрсдлүүд энэ насны бүлэгт тохиолдож байна. Судалгаанаас үзэхэд эрүүл, эсэн мэнд байх нь амин чухал бөгөөд ирээдүйдээ итгэлтэй, хөдөлмөрч, ухаалаг, идэвхи санаачлагатай байх явдал энэ насны сайн сайхан амьдралын гол учиг ажээ.

Хижээл болон ахмад настны амьдралын чанар.Энэ ангилалд 46 болон түүнээс дээш насны хүмүүсийг багтаан авч үзсэн. Орчин үед глобаль шинжтэй болоод байгаа асуудлын нэг нь манай дэлхийн хүн ам хөгширч буй үйл явц юм. НҮБ-ын мэдээгээр 1950 онтой харьцуулж үзсэн дүнгээр 2025 он гэхэд дэлхийн нийт хүн ам 3 дахин өсч байхад ахмад хүмүүсийн тоо 6 дахин, өндөр настны тоо /80- аас дээш насны/10 дахин өсөх хандлагатай байна. Хөгжингүй улс орнуудад хүн амын хөгшрөх үйл явц ойролцоогоор 30-аад жилийн тэртээгээс эхэлж нэлээд эрчтэй явж байна. Нийгмийн ажилтнуудын тодорхойлсноор манай орны хүн амын насжилтдараах онцлогтой байна. 1.Ахмад насны хүн амын доторх 80 болон түүнээс дээш өндөр настнуудын тоо нэмэгдэж байна. 2.Ахмад насны хүн амын дотор эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна. Ажилгүйдэл улс орны хэмжээнд түгээмэл байгаагийн улмаас ахмад настнуудын хувьд үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэх, тэтгэвэрээс гадуур орлого олоход улам бүр бэрхшээлтэй болж байна. Насжилтын индексээр авч үзэхэд 65-с дээш насны нэг хүнд ноогдох хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч байгаа нь орлогын баталгаа алдагдахад хүргэж байгаа болно. Монгол Улсад ахмад настай хүмүүс ажил хөдөлмөр эрхэлж орлого олох явдал ихээхэн хязгаарлагдмал байгааг ахмад настнуудын ердөө 12.3 хувь нь ямар нэг хөдөлмөр эрхэлж байгаа статистикийн баримтад түшиглэн тайлбарлаж болох юм. Шилжилтийн он жилүүдэд ахмад настнуудын хувьд тэтгэвэр цагтаа олгогддоггүй байсан нь гол бэрхшээл байсны зэрэгцээ өнөөгийн нөхцөлд тэтгэвэр тэтгэмж өрх гэр бүлийн орлогын тодорхой хувийг бүрдүүлэх хүчин зүйл болж байна. Азийн улс орнуудад хийгдсэн Ахмад настны амьдралд тэтгэвэрийн үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаанаас үзэхэд¹²⁴ тэтгэвэр нь тухайн өрхийг ядууралд

¹²⁴Н.Оюут-эрдэнэ болон бусад. Ахмад настнуудын амьдралын чанарт үзүүлэх тэтгэвэрийн үр нөлөө. НАБСХ.УБ., 2007.

өртөхөөс сэргийлж, өрхийн гишүүдийн дунд халуун дулаан эерэг харилцаа бий болгоход нөлөөлдөг гэжээ. Монгол дахь хижээл болон ахмад настнуудын нөхцөл байдлыг баримт бичиг болон чанарын судалгаанд түшиглэн авч үзэхэд,

- Шилжилтийн дунд хугацаанд буюу 1995-2000 онд хийгдсэн судалгаагаар¹²⁵ Монгол Улсын хүн амын 32 хувь нь ядуу байсан бөгөөд ахмад настнууд ядууралд өртөмхий байгааг тэмдэглэсэн.
- Өөрсдийн болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангаж чадахгүй ахмадууд өөрсдийгөө “ядуу” хэмээн үзэх хандлага түгээмэл байна.
- Ахмад настны ихэнх нь өөрийн гэсэн өмчтэй ч, сар бүр тэтгэвэр, тэтгэмж авдаг учраас дундаж ядуу бүлэгт багтаж¹²⁶ байна.
- Ганц бие, тэдэнд туслах хүүхэд, хамаатан садан байхгүй ахмад хүмүүсийн ихэнх нь “нэн ядуу” бүлэгт¹²⁷ хамаарагдаж байна.
- Ахмад настны тэтгэвэрийн ихэнх нь тэдгээрийн үндсэн хэрэгцээнд буюу хоол хүнс, эм эмчилгээнд зарцуулагдаж байна.

Ядуу буурай хөгжилтэй улс орнуудыг энэ үйл явц хараахан хамраагүй ч, НҮБ-ын хүн ам зүйчдийн тооцоолж байгаагаар эдгээр улсад төрөлт эрс багасч байгаа нь ирэх 10 жилээс хүн амын хөгшрөх үйл явц идэвхжиж эхлэхээр байна.

Товч дүгнэхэд олон хүүхэдтэй байх нь амьжиргаа тааруу, ядуу өрхийн үндсэн нөхцөл болдгийг судалгааны тайлангаас¹²⁸ харж болохын зэрэгцээ нөгөө талаас уламжлалт хэлц болох “үртэй хүн баян”, “олуулаа бужигнаж өсөх”, “өнөр өтгөн байх” зэрэг уламжлалт хандлагад өөрчлөлт орж байна. Өнөөгийн залуучуудын гэрлэх нас хойшилж, улмаар ганц биеэр амьдрахыг илүүд үзэх болов. Эл хандлага залуу насны эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хувьд аль алинд нь тохиож байгаа болно. 18-аас дээш насны хүн амын дунд гэрлээгүй хүн амын эзлэх хувь нэмэгдэж, 1989 онд гэрлэх насны 4 хүн тутмын нэг, 2000 онд 3 хүн тутмын нэг нь огт гэрлээгүй байна. Анхны гэрлэлтийн нас хойшилж, эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24 насандаа тус тус гэрлэх болжээ. Түүнчлэн гэр бүлтэй нийт хүн амын 12.8 хувийг хамтран амьдрагч буюу хууль ёсоор гэрлэлтээ батлуулаагүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн 20-35 насныхны дунд эл хандлага зонхилж байна¹²⁹. Нийгэмшилтийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцох, эрх эдлэн үүрэг хүлээх, өрх гэр толгойлж, үр хүүхэдтэй болох нэг үгээр амьдрал зохиох нас хойшилж байгаа нь залуус эцэг эхээс өрх тусгаарлах, үр хүүхэдтэй болж өсгөх, иргэний үүрэг хариуцлагаас хойш суух, буруу зуршилд автах зэргээр сөрөг нөлөө үзүүлсээр байна

МУЗГ-аас 2003 оноос эхлэн хүн амын өсөлт, өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих зарим нэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн явдал бол нийгмийн хамгааллын чухал асуудлуудын нэг байсан. Тухайлбал, “Шинээр төрсөн хүүхэд”, “Анх удаа гэрлэгсэд”, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрүүд нь залуу гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдийн ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар гэр бүлийн тогтвор суурьшил болон өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болсон.

УИХ-аас Гэр бүлийн тухай хууль[1999], Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого[2003], Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль[2004], Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг бодлого, хууль эрхийн баримт бичгийг батлан гаргаж, гэр бүлийг хөгжүүлэхэд төр засаг болон нийгмийн анхаарлыг хандуулсаар ирсэн. Нөгөөтэйгүүр залуу гэр бүлийн хөгжлийг

¹²⁵ҮСХ.Хүн ам, орон сууцны тооллого, Монголын ахмад насны хүн ам. УБ., 2000.

¹²⁶ ҮСХ, АХБ, Дэлхийн банк. Оролцооны аргаар ядуурлыг үнэлэх судалгаа. УБ., 2006.

¹²⁷ҮСГ. НХХЯ, НҮБ-ын Хүн амын сан. Ахмад настны ахуйн нөхцлийн түүвэр судалгаа. УБ., 2001.

¹²⁸ҮСГ.Өрхийн орлого зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа.УБ., 2003.

¹²⁹Монгол Улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Азийн хөгжлийн банк, “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”судалгааны тайлан. УБ., 2010.

дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, Монгол ёс заншил, уламжлал, соёлыг сэргээн хүүхэд, залууст өвлүүлэх явдал ихээхэн чухал байна.

2014 оноос Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих үндэсний хөтөлбөр, ”Миний гэр бүл” хүүхэд хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх талаар холбогдох яам газрууд санал дэвшүүлэн, хөтөлбөр баталж, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг байгуулж олон улсын жишигт нийцсэн стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн боловсролын хөтөлбөр боловсруулж бүх шатны сургалтын төлөвлөгөөнд оруулах, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар батлуулж хэрэгжүүлэх талаар зохих шатанд хэлэлцэж байна.

Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх асуудлыг төрийн бодлогод тусгах нь

Хүн амын амьдралын чанар бол аль ч улсын хувьд тулгамдсан шинжтэй нийгэм, эдийн засаг, хүний хөгжил, амьдрах орчны суурь үзүүлэлтийн нэг юм. Өмнөх хэсэгт дурьдсанаар манай хөрш улсуудын хувьд ч хүн амын амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр бодлого, стратеги баримталдаг. Тухайлбал, Орос улсын хувьд иргэдийн амьдралын чанарын гол үзүүлэлтээр иргэдээ дэлхийд тэргүүлэгч орны тоонд оруулах бодлого баримталж буйгаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн индрээс¹³⁰ “...хямрал манай орныг ялгаагүй дайрсан хэдий ч хүн амын нийгмийн асуудлыг зохих түвшинд шийдвэрлэсэн, нийгэм, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбарт хүн амын орлогын түвшинг харгалзан орон сууц барих, бүх хүн амыг ажлын байраар хангах үндэсний өргөн хүрээтэй төслийг хэрэгжүүлж... өрхийг дэмжиж, нийгмийн эмзэг давхаргын иргэдэд анхаарал тавих нь Орос Улсын тэргүүн зэргийн зорилт” гэжээ. Харин Хятадын хувьд 2010 оноос хойш “Үндэстний нийт аз жаргал”[Gross National Happiness] гэсэн хэмжүүрээр хөгжлөө тодорхойлж¹³¹ эхэлсэн явдал юм.Хятад улсын хувьд амьдралын чанарын судалгаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд ард иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлж, аз жаргалтай байлгахад үндэсний нийт бүтээгдэхүүний тасралтгүй өсөлтийг харгалзан үзэх төдийгүй ард иргэдийн амьдралын чанартай шууд холбогдох эмчилгээ, боловсрол, орон сууцаар хангахыг чухалчлах болсон. Түүнчлэн тус улсын хувьд хууль ялгаваргүй, эрх тэгш, шударга хэрэгжүүлэхэд анхаарч, авлига, хээл хахуультай тэмцэж буй нь ард иргэдийн сэтгэл ханамж, аз жаргалыг хангах хууль эрхийн нэгэн нөхцөл болдог. Хятадын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Зябао ХКН-ын хурал дээр/хуучнаар/“ард иргэдийг аз жаргалтай байлгана гэдэг бол амгалан тайван, сэтгэл хангалуун, ирээдүйдээ итгэл төгс байх явдал юм, Эдийн засгийг хөгжүүлэхийн гол зорилго бол иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд оршино” хэмээсэн нь тус улсын хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх төрийн бодлогын цөм ажээ.

Дурьдсан чиглэл тус бүрээр бодлогын шинжилгээ хийх ерөнхий аргачлалын дагуу тулгамдаж буй асуудал, тухайн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг хүн амын насны бүлэг тус бүрээр авч үзэж дүгнэсэн.

Олон улсын амьдралын чанарын индексийн судалгаанд хүн амын амьдралын чанарыг дэмжих бодлогогүй, энэ талаар харьцуулах мэдээлэл байхгүй улс орны тоонд Монгол Улсыг багтаасан байна. Хэдийгээр олон улсын түвшинд нөхцөл байдал ийм боловч тус орныг хүн амын бүлгүүдэд чиглэсэн, тэдгээрийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр юу ч хийгээгүй гэвэл алдаатай дүгнэлтэд хүрнэ. Учир гэвэл, ерөөс нийгэм, хүн ам зүйн талаар тодорхой бодлого байхгүй байна гэдэг нь зүйрлэвэл толгойгүй төр, хүнгүй улстай адил. Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх талаар баримталж байсан социалист төрийн бодлогын хувьсал өөрчлөлтөөс өнөөгийн Монголчуудын амьдралын чанарын нөхцөл байдал, үнэлгээ үндсэндээ хамаарч буй юм Социалист нийгмийн үеийн төрийн бодлого хүн амын амьдралын чанарын объектив нөхцлийг сайжруулахад дорвитой үүрэг гүйцэтгэжээ. Энэхүү амжилтад хүн амын эдийн засаг, нийгмийн байр суурийн өсөлтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогоор дамжуулан нэмэгдүүлэх, социалист бие хүнийг төлөвшүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлсэн

¹³⁰ОХУ-ын төлөөлөгч Николай Раковский. НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хэлсэн үг.

¹³¹<http://mongol.cri.cn/343/2011/03/04/61s150656.htm>./Татаж авсан хугацаа: 16/03/04/2011

явдал үр дүнгээ өгсөн юм. Энд бид социалист байгуулал задарсны дараах, зах зээлийн харилцааны буюу хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн төрийн бодлогод дүн шинжилгээ хийх болно. Өөрөөр хэлбэл, ардчилсан төр засаг байгуулагдсанаас хойшхи хугацаанд хүүхэд залуус, хижээл болон ахмад настнуудад зориулж хэрэгжүүлсэн төр, улс төр, улс төрийн намын төсөл, хөтөлбөр, бодлого үйл ажиллагааг бүхэлд нь энэхүү сэдвийн хүрээнд нэгтгэн авч үзэх боломжгүй тул хүн амын бүлгүүдэд чухал нөлөө үзүүлсэн төрийн асрамж хамгаалал, халамж дэмжлэгийн үр нөлөөнд шинжилгээ хийхээр хязгаарласан.

Манай улсын хүн амын 30 орчим хувийг эзэлдгийн хувьд, хүн ам зүйн болон нийгмийн халамжийн бодлогод өсвөр үе, хүүхдийн асуудал чухал байр суурь эзэлж байна. Шилжилтээс хойшхи хугацаанд Монгол Улсын төрийн бодлогод хүүхдийн сайн сайхан байдлыг хангах, аюулгүй амьдралын нөхцлийг дээшлүүлэх, асран хамгаалах чиглэлээр олон тооны бодлого боловсруулж, хэрэгжүүлжээ.

Хүүхэд, өсвөр үеийг асран хамгаалах чиглэлд. Хүүхэд эмзэг төдийгүй эрсдэлтэй бүлгийн цөм байсаар байна. Монгол Улс Үндсэн хуулиндаа \16.11\ “гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална” гээд ... хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнээс төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалал, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай тул эцэг эх, төр хамгаалахын чухлыг тунхаглажээ. Түүнчлэн 1996 онд батлагдаж, 2015 онд шинэчлэгдэн мөрдөгдөж буй Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7-р зүйлийн 1-д ...Хүүхдийг гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эхээс нь тусгаарлаж болно. Энэ нөхцөлд хүүхэд төрийн асрамжид байна. 7-р зүйлийн 2-д...Хүүхэд нэр төр, эрүүл мэнд хувийн болон захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлаа хамгаалуулах эрхтэй. хэмээн заасан байна. Хуулинд зааснаар “Хүүхдийн сайн сайхан байдлыг хангах гол институт бол гэр бүл, гэр бүлийн орчин” байхаар зааж өгчээ. Энэ агуулгаар УИХ-аас Гэр бүлийн тухай хууль[1999], Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого[2003], Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль[2004], Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг бодлого, хууль эрхийн баримт бичгийг батлан гаргаж, гэр бүлийг хөгжүүлэхэд төр засаг болон нийгмийн анхаарлыг хандуулсаар ирсэн. 2014 оноос “Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих үндэсний хөтөлбөр”, ”Миний гэр бүл” хүүхэд хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх талаар холбогдох яам газрууд санал дэвшүүлэн, хөтөлбөр баталж, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг байгуулж олон улсын жишигт нийцсэн стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн боловсролын хөтөлбөр боловсруулж бүх шатны сургалтын төлөвлөгөөнд оруулах, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар батлуулж хэрэгжүүлэх талаар зохих шатанд хэлэлцэж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2003 оноос эхлэн хүн амын өсөлт, өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих зарим нэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн явдал бол өнөөгийн хавтгайрсан нийгмийн хамгааллын бодлогын эхлэл байжээ. Хэдийгээр “Шинээр төрсөн хүүхэд”, “Анх удаа гэрлэгсэд”, “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрүүд нь залуу гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдийн ирээдүйд хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар гэр бүлийн тогтвор суурьшил болон өрх гэрийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ байсан. Хүний амьдралын чанарыг сайжруулах тухай хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 3-р бүлэгт нийгмийн хамгааллын бодлогын ерөнхий таван чиглэлийг тусгасан нь нийгмийн хамгааллын үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, гэр бүл хамт олонд түшиглэсэн хэлбэрийг нэмэгдүүлэхээр тогтоосон юм. Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь үүсээгүй, бие даан амьдрах чадваргүй, тэтгэж туслах үр хүүхэд, ах дүү, төрөл садангүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг 30 гаруй мянган хүн нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр авч байна. Олон хүүхэдтэй, жирэмсэн ба амаржсаны амралттай, нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, өнчин хүүхдүүд зэрэг 200 гаруй мянган хүнд

нийгмийн халамжийн сангаас тэтгэмж, тусламж олгож, нийгмийн эмзэг хэсгийн 400 гаруй мянган хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Өнгөрсөн хугацаанд хүүхэд зөвхөн гэр бүлдээ бус гэр бүлээс гадуурх орчин болох сургууль, гудамж талбай, амьдрах бусад орчинд аюул, дарамт хүчирхийлэлд өртөхгүй байх, “хүүхдэд ээлтэй орчин” бүрдүүлэх, хүүхэд хамгааллын хамтарсан багийг зохион байгуулалтад оруулж, аргачлалаар хангах, төвлөрсөн асрамжийн газарт хяналт үнэлгээ хийх, хүүхдийн халамж асрамжийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх, чиглэлээр төрөөс олон улсын байгууллагуудтай/ДЭМБ, ОУХБ, ЯХИС, Дэлхийн зөн, Амичи де бамбини гм/ хамтран олон тооны ажлыг хийсээр байна. МУЗГ-ын 5 дугаар тогтоолоор “Биеийн тамир- эрүүл мэнд” уриан дор “Өсвөр үеийнхэн залууст ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г санаачлан НҮБХАС, ДЭМБ-ын мэргэжил арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр ээлтэй үйлчилгээ үзүүлэх клиникүүдийг байгуулсан байна. Гэвч эдгээр үйл ажиллагаа төслийн хэмжээнд, хэрэгжиж дууссан бөгөөд цаашид төр засгийн зүгээс урт хугацаанд бодлого болгон хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ (А.Батхишиг, Н.Мөнгөнтуул, 2015)-нд дурьдсанаар, өнгөрсөн хугацаанд хүүхдийн эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахтай холбоотой Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх үндэсний стратеги (2010-2015), Хүүхдийн оролцоог дэмжих үндэсний стратеги (2011), Хүүхдийн гэвчишгүй хөдөлмөрийг устгах үндэсний хөтөлбөр (2012-2016), Өсвөр үе, залуучуудыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Жендэрийн тэгш байдлын тухай үндэсний хөтөлбөр зэрэг үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжсэн.

Цаашид хүүхэд хамгааллын чиглэлээр өнөөгийн хүрсэн түвшинг ахиулах, мэргэжилтэн шинжээчдийг чадавхижуулах, хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэдтэй зүй бус харьцах болон бүх төрлийн шийтгэлийг халах чиглэлд бодлого боловсруулан ажиллах нь амьдралын чанарыг дээшлүүлж, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах үндсэн нөхцөл болно.

Залуусыг дэмжих тухайд. Монгол Улсын хүн амыг бүрдүүлэгч үндсэн цөм бол залуучууд юм. Тэрчлэн хүн амын бүлгүүдээс хамгийн үр бүтээлтэй байж болох, мөнхүү хамгийн их эрсдлийг хүлээж буй бүлэг бол залуучууд болно. Эрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрөөс үзэхэд ядуу буюу орлого багатай хүн ам болох залуучууд, тухайлбал чинээлэг амьдралтай бүлгийн хүмүүсийг бодвол ядуу болон дунд зэргийн амьдралтай хүмүүс эрүүл мэндийн салбарын үйлчилгээг харьцангуй бага хүртэж байна.

Судалгааны баримтаас үзэхэд өнөөгийн Монголын залуучууд “албан ёсоор гэрлэлтээ батлуулдаггүй, хамтран амьдардаг шалтгаанаа өөрийн гэсэн орон гэргүй байгаагаас үүдэлтэй” хэмээсэн нь төрийн зүгээс анхаарвал зохих бодлогын асуудал юм. Учир гэвэл орлого багатай залуу гэр бүлийг орон сууцтай болгох талаар төрөөс оновчтой бодлого өнөө хэр нь гаргаагүй. Монгол Улсын төр засгаас хүчин чармайлт гаргаж дөрвөн мянга, дөчин мянга, зуун мянган айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч бодит байдалд орон сууцны үнийг хөөргөдөхөд хүргэж, 2008-2010 оны хооронд орон сууцны үнэ 50-80 хувиар нэмэгдсэн байна. Ингэснээр ихэнх залуу гэр бүл орон сууц худалдан авах хүндрэлтэй тулгарч, орон сууц худалдан авсан нь банк санхүүгийн барьцаа, өр зээлийн дарамтад өртөх болжээ. Залуучуудын хувьд хуримтлал үүсгэх бус, өнөөдөр олж буй орлогоо орон сууцны зээл, банкны өр зээлэнд тушааж буй нь нууц биш юм. Гэтэл залуусын хувьд одоогийн эрхэлж буй ажил тийм ч баталгаатай бус байгаа нь цаашид тулгарах эрсдэл, ирээдүйн баталгаагүй байдлын эхлэл болж байна. Ажилгүйдэл, орлогын хомсдол, эрүүл мэндийн баталгаагүй байдал зэргээс үүдэн залуучуудын нийгмийн баталгаа алдагдаж байна. Ялангуяа залуусын эдийн засгийн болон нийгмийн баталгааг тэд өөрсдөө биш, төрөөс бус, харин гэр бүлийн гишүүд, эцэг эхчүүд зонхилон үүрч байна. Хөдөлмөр эрхэлж байгаа Хүн ам зүйн бүлгүүдийн дийлэнхи олонхи нь албан бус сектор ажиллаж байгаа нь цалин орлого тогтворгүй болох, улирлын чанартай ажил хөдөлмөр эрхлэх, ажлаас халагдах, ажилгүй болох, сэтгэл санаагаар унах, зэрэг олон тооны эрсдлийг дагуулж байна. Анх удаа гэрлэгсдийг төрөөс дэмжих 500 мянган төгрөгийн дэмжлэг залуусын гэрлэлтийн түр зуурын өсөлт болон салалт ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлжээ. Энэ хугацаанд төр засгийн зүгээс залуучуудын боловсролыг дэмжих бодлогод алдаа, ахиц

дэвшлийн аль алин нь гарсан. Монгол Улсын төрөөс явуулж буй дээд боловсролын бодлогын алдааны улмаас олон тооны чанаргүй их дээд сургуулиуд үүсч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй салбар, мэргэжлүүд, мөн чадавхи муутай, мэргэжлийн дадал байхгүй боловсон хүчин олноор бэлтгэгдэн гарсан. Ингэснээр ажилгүйдлийн өндөр түвшин, сул байгаа ажлын байрны өндөр түвшин зэрэгцэн оршиж байна. 2010 онд Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооноос хийсэн судалгаанаас харахад мянган ажлын байр сул байхад, зуун мянган ажилгүйдчүүд бүртгэлтэй байжээ. Энэ зөрүү нь их дээд сургуулийн дийлэнх нь уул уурхай, барилга, дэд бүтцэд эрэлттэй байгаа байгалийн шинжлэл, инженер техникийн чиглэлээр боловсон хүчин бэлтгээгүйтэй зарим талаар холбоотой ажээ. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин өндөр болж буй нөхцөлд, хүн амд тэжээгдэгч насны бүлэг(0-15, 65-с дээш насныхан)-ийн эзлэх хувийн жин буурснаар тэжээгчийн ачаа хөнгөрч, өрхийн хуримтлал хадгаламж нэмэгдэх, улсын төсөв хийгээд боловсролын чанарт ахиц гарах боломжтой. Гэсэн хэдий ч залуучуудын түрэлтийн энэ хугацаанд ажил хөдөлмөр эрхлэхгүй, сурч боловсроход тэмүүлсэн, сонгуулийн амлалттай холбоотой тэтгэмжийн зардлыг өсгөснөөр нийгмийн хамгааллын тогтолцоонд дарамт учруулж, төсөвт бэрхшээл авчирсан байна.

Хэдийгээр өнгөрсөн хугацаанд Залуучуудын талаар төрөөс баримтлах хөтөлбөр¹³²/1996, 2006/ батлагдан хэрэгжсэн боловч, төрийн зүгээс баримталж буй нийгмийн бодлогын хэрэгжилт уялдаа холбоогүй¹³³, залууст тулгамдаж буй орон байр, ажил хөдөлмөр, ахуй хангамж, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй, соёл төлөвшлийн бодлого байхгүй, орхигдмол шинжтэй явж ирсэн байна.

Хөгшидийг тэтгэх хүрээнд. Хөгшид хөвөөд эмзэг бөгөөд ядуу бүлэг байсаар байна. Дэлхийн банк, ҮСХ-ны мэдээллээр одоогийн нөхцөлд хүн амын таван хүн тутмын нэг ядуурлын буюу эмзэг эрсдэлтэй нөхцөлд амьдарч байна. 65-с дээш настай ахмад болон өндөр настнуудын дунд ядуурал өндөр хувьтай байгаа нь ядуу хэсгийн тодорхой хувийг бүрдүүлж байгаа болно. Монгол Улсын Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт дурьдсанаар Нийгмийн хамгааллын салшгүй нэг хэсэг болох нийгмийн халамж нь нийгмийн эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх, нэн ядуу амьдралтай, бие даан амьдрах чадваргүй иргэдийг халамжлах, асрамжлах замаар тэдний амьдралын баталгааг хангах зорилготой.

Ахмад настнуудын хувьд тэтгэвэрийн хэмжээ бага, тэтгэвэрээс гадуур орлого олоход бэрхшээлтэй байгаа нь орлогын баталгаа алдагдах, улмаар ядуу, эмзэг бүлэгт орох үндсэн шалтгаан болж байна. Шилжилтийн явцад ахмад настны гол орлого болсон тэтгэвэр тэтгэмжийг олгохгүй байх нь тэдний амьдралд ихээхэн хүндээр тусч байсан бол шилжилтийн дунд хугацаанд буюу 1995-2000 онд хийгдсэн судалгаагаар ахмад настнууд ядууралд ихээхэн өртөмхий бүлэг болохыг тодорхойлжээ.

Нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоо нь хүн амд халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох замаар бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож, ядууралд улам түлхээс болсон, нэг хүнд ноогдох үйлчилгээний хүртээмж харьцангуй бага, хүн амын амьжиргаанд үзүүлэх бодит нөлөө тааруу боловч нэгдсэн дүнгээрээ ихээхэн зардал гаргадаг сул талтай тогтолцоо юм. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид 1997 онд 7 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2001 онд 20 гаруй тэрбум болж бараг 3 дахин өссөн бол 2010 онд энэ дүн 10 дахин өссөн. Гэвч нэг хүнд ноогдох орлого төдийлөн нэмэгдэж чадаагүйгээр үл барам ядуурлыг 20 орчим жилийн өмнөхөөс 10 гаруйхан хувиар бууруулсан байна.

Жил ирэх тусам нийгмийн хамгааллын зардал өсөж байгаа ч, ядуугаас ядуу бус хүн амд голчлон зарцуулагдаж байгаагаас үүдэн хамрагдах ёстой хүн ам нийгмийн хамгааллын гадна орхигдохын сацуу ядуурлыг бууруулах бодит үр нөлөө тааруу байгаа болно.Одоогийн

¹³²Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого. УИХ-ын 1996 оны 22р тогтоол. УБ., 1996. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2006 оны 282-р тогтоол. УБ.,2006

¹³³2000-2010 он хүртэлх 10 жилийн хугацаанд 63.7-72.7 хувь хүртэл өссөн. Энэ үеийг хүн амын цонх үе буюу бонус гэж нэрлэдэг. МУЗГ. НҮБХАС. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөлөл. УБ., 2012

хэрэгжүүлж нийгмийн халамжийн бодлогын “хавтгайрсан”, хэт олон арга хэрэгслийг эмзэг бүлэгт хандуулан оновчтой зохион байгуулах, хөдөлмөрт шилжүүлэн шинэчлэх зайлшгүй шаардлага зүй ёсоор үүсч байна.

▪ **Эдийн засгийн амьдралын хүрээнд:**

Шилжилтийн дунд хугацаанд эдийн засгийн өсөлт тогтворгүй, зарим жилүүдэд эргээд буурсан бол, урт хугацаанд авч үзэхэд Монгол Улсын эдийн засгийн нөхцөлд өсөлтийн ерөнхий чиг хандлага ажиглагдаж байна. Эдийн засгийн тууштай өсөлт сэргэлт 2004 оноос эхэлсэн ба 2006-2008 оны хооронд эдийн засаг бүхэлдээ тэлж, өссөн нь харагдаж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт нь хүн амын амьдралын чанарт тодорхой бөгөөд шийдвэрлэх нөлөөтэй байсангүй. Статистикийн мэдээллээс үзэхэд ядуурлын түвшин 2014 оны байдлаар 21.4 хувьтай байгаа нь 20 жилийн өмнөхөөс 15 орчим хувиар, 2010 онтой харьцуулахад 11 хувиар, одоогоос хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 5.4 хувиар тус тус буурсан нь хангалтгүй үзүүлэлт юм. Анх 1991 онд өмч хувьчлах тогтоол гарсан ба үүнтэй холбоотойгоор малыг малчдад хэмээх уриаг амьдрал дээр хэрэгжүүлж, томоохон аж ахуй, хоршооллын өмч хувьчлагдсан нь шилжилтийн үеийн эдийн засгийн хямралыг бий болгож, өмчийн ялгаа үүсэх эхлэл тавигдсан. 1994 оны нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлээс үүдэн Монгол Улс анх удаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Юуны өмнө шилжилтийн эхэн үе болох 1990-1993 онд өрхийн амьжиргааны түвшин илт доройтож, ажилгүйдлээс үүдэлтэй орлогын хомсдол нүүрлэж, хуримтлал үүсгэж чадахгүй, орлогын ихэнх хэсгийг өдөр тутмын хүнсний хэрэглээнд зарцуулж, товчхондоо Монгол өрх, гэр эдийн засгийн хувьд ихээхэн хүнд дарамттай тулгарч байжээ. Энэ үед МУЗГ-аас өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын төрөл хэлбэрийг тодорхойлон, улмаар өрхийн үндсэн хэрэгцээг хангах бодлогыг авч хэрэгжүүлсэн байна.

Шилжилтийн дунд үе болох 1994-2004 онд өрхийн амьжиргаанд тулгамдаж буй олон асуудлууд шийдвэрлэгдэж, ядуу өрхийн амьжиргааг төр засгийн зүгээс системтэйгээр дэмжиж эхэлжээ. Тухайлбал, хандивлагч улс орнуудын дэмжлэгтэйгээр өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлал боловсруулан, хүн амын амьжиргааг дэмжих бодлогууд болох Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр(1994-2000), Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги(2003)-ийг баталж, хандивлагч орнуудын дэмжлэгтэйгээр өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Энэ үед өнөөгийн Монгол өрхийн амьдралын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, амьжиргааны түвшин дээшлэх, өөрчлөгдөн хөгжих суурь тавигдсан болно. Мөн хугацаанд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох болсон, төрийн албан хаагчдын хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлж, сургалтын төрийн сангаас оюутны төлбөрт төрөөс олгосон хөнгөлөлттэй зээлийг цуцлах замаар барьцаалсан дипломыг буцаан олгох шийдвэр гаргасан зэрэг нь төрөөс дээд боловсролын салбарт ажиллах, мэргэжилтэй боловсон хүчнийг дэмжсэн бодитой алхам байжээ.

Шилжилтийн дараах үе буюу 2005-2008 онд өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлогод эрс өөрчлөлт гарсан. Улс төрийн намуудын сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөр, улмаар хамтарсан засгийн газар байгуулсантай холбоотойгоор өрхөд үзүүлэх нийгмийн халамжийн тоог нэмэгдүүлэн, ажил эрхлэлтийг дэмжих замаар өрхийн амьжиргааг дэмжин, ядуурлыг бууруулах олон тооны бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн болно. Энэ хугацаанд ялангуяа залуусыг эдийн засгийн тусгайлсан арга хэмжээ байхгүй боловч төрийн бодлогын зарим хэсэгт тусгагдан шийдвэрлэгдэж байсан юм. Сонгуулийн зарим популист амлалттай холбоотойгоорхүүхэд болон залуучууд, насанд хүрэгчдэд олгох мөнгөн дэмжлэг өрхийн эдийн засгийг дэмжихэд зохих хэмжээгээр нөлөөлсөн.

Ингэснээр хүн амын залуу хэсэгт хандсан боловсрол, нийгмийн хамгааллыг дэмжих, амьжиргааг сайжруулах нийгэм-эдийн засгийн дараах хөтөлбөр хэрэгжсэн бөгөөд үр шимийг нь багагүй хүртсэн залуучуудын дундах цөм бөгөөд өвөрмөц бүлэг бол оюутнууд юм.

“Хүний хөгжил сангийн тухай” хууль батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай” болон “Эх, хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэрбүлд мөнгөн

тусламж үзүүлэх тухай” хуулиуд 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчингүй болж, шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж, шинээр гэрлэгсдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж (Залуу гэр бүлд олгох 500.000 төгрөг), шинэ төрсөн хүүхдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж, “Монгол Улсын хөгжүүлэх сангийн тухай” хуулийн дагуу олгож байсан хүүхдийн мөнгө тустус олгогдохгүй болсон ба оюутнуудад “Хүний хөгжил сан”-гаас 500 мянган төгрөг олгох болжээ.

Хүн амыг насны бүлгээр авч үзэхэд ялангуяа залуучууд амьжиргааны түвшин, эдийн засгийн байдлын хувьд хүн амын насны бүлгийн дотор харьцангуй доогуур түвшинд орж байгаа нь тэднийг эмзэг байдалд түлхэн оруулах үндсэн хүчин зүйл болж байна. Өнөөгийн залуусын талаас илүү хувь нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээнээс илүү гарч чадахгүй байгаа явдал бол тухайн бүлгийн амьжиргаа тааруу, хэрэгцээ хангалт “тарчигхан”, эдийн засгийн агуулгаар ядуурлын нөхцөлд байгаа хэрэг мөн.

Хижээл насны бүлгийн орлогод цалин гол эх үүсвэр болж байгаагийн зэрэгцээ цалингийн хэмжээ бага байгаа нь тухайн хүн ам, өрхийг санхүүгийн эмзэг байдалд оруулахад нөлөө үзүүлж байна.

Хөдөлмөр эрхлэх эсэх нь өнөөгийн хөдөлмөрийн насны хүн амын эрх хэмээн орхиж болохгүй бөгөөд, өнөөгийн хөдөлмөрийн насны идэвхитэй хүн амын дунд байгаа ажилгүйдэл бол хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн болон боловсролын байгууллагаас бэлтгэж буй мэдлэг чадвар муутай боловсон хүчин хоорондын эрэлт нийлүүлэлтийн зөрчлийн үр дүн мөн. Амьжиргааны түвшин, орлого зэрэг эдийн засгийн байдлын хувьд хамгийн их гадуурхагдсан, баялгийн хуваарилалтаас хоцорсон бүлэг бол тэтгэвэрийн хөгшчүүд хийгээд амьдралд дөнгөж хөл тавьж байгаа залуучууд болох нь олон тооны суурь судалгааны дүнгээр¹³⁴ батлагдсан зүйл юм. Зах зээлийн нийгэмд шилжих үеийн эдийн засгийн хямрал, орлогын тэгш бус хуваарилалтад өртсөн бүлэг бол залуус, түүнчлэн ажилгүйдлийн эгнээнд үй олноор шилжигсэд, шилжилтийн үеийн “архаг ядуурал”(угшмал ядуурал)-ыг өвлөн авагсад нь мөн л залуусын бүлэг билээ.

Ялангуяа залуучуудын ажилгүйдэл, одоогийн олж буй цалин орлого бага болон эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байгаа явдал нь тэднийг гадаадад хөдөлмөр эрхлэх замаар эдийн засгийн эмзэг байдлаа даван туулах үндсэн шалтгаан болж байна. Хэдийгээр гадаадад хөдөлмөр эрхлэх нь цалин орлогоо нэмэгдүүлэх бодит боломж хэдий ч, хүн амын эрүүл мэнд, аюул осолгүй нөхцөлд ажил эрхлэх зэрэг эрхийг ноцтой зөрчиж байна. Энэхүү нөхцөл байдал дотоодын барилга болон уул уурхайн салбарт мөн тохиолдож байна.

Монгол Улсын эдийн засгийн ихэнх бодлого гадны хандивлагчдын зээл тусламж, бодлого, үйл ажиллагаанд тулгуурлан явагдсан ба уул уурхайн болон хөгжлийн томоохон төсөл, хөрөнгө оруулалт хүн амын амьдралд эерэгээр нөлөөлсөнгүй. Урт хугацаанд авч үзвэл улс орны амьдралын нөхцөл сайжраагүй хэрнээ зээл тусламжаас хараат орон болсон байна. Ингэснээр иргэдийн зүгээс төрийг үнэлэх, төрд итгэх итгэл жилээс жилд буурч байна.

■ **Нийгмийн амьдралын хүрээнд:**

Өнөөгийн хүн амын хувьд мөнгөн орлого хомс, хэрэгцээгээ хангах байдал хязгаарлагдмал байгаа нь тэдгээрийн нийгмийн амьдралд эзлэх байр суурь, анги давхаргын байдал, харилцааг тодорхойлох гол хүчин зүйл болж байна. 2013 онд эрхлэн явуулсан суурь судалгааны дүнгээс үзэхэд залуу өрхийн орлогын хүрэлцээ тааруу байгаа нь анхаарал татаж байна. Нийт залуу өрхийн 54.1 хувь нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээгээ хангах төдийгөөр “тарчигхан” байдалтай амьдарч байгаа юм. Залуусуралцах, гэрлэж өрхтусгаарлах, хүүхэд өсгөхөд олон төрлийн зайлшгүй зардалүүсэх, улмаар хүүхэд төрж өрхийн гишүүн ажилгүй болох, цалин орлогогүй болох үед залуусына амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дорддог байна. Түүнчлэн

¹³⁴ Монголын Залуучуудын хөгжлийн хэрэгцээ: суурь судалгааны тайлан. МЗХ-ны Полиси төв УБ., 2002-2003.

НАМЗХ, Социологийн Боловсрол төв. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан. УБ., 2013.

залуус олж буй орлого, амьжиргааны түвшингээс үл хамаарч өөрсдийгөө нийгмийн дунд давхаргад оруулж үзэх явдал нийтлэг байна. Энэ нь судлаачдын тэмдэглэснээр алтан дунджийг баримталдаг зарчим, одоогийн нөхцөл байдлаар ирээдүйд сайжирна гэсэн өөдрөг төсөөлөл, мэдрэмж хүлээлттэй холбоотой байна. Тогтвортой хэрэглээг дэмждэг, хэрэгцээг үүсгэдэг, нийгэм эдийн засгийн гол тулгуур болох нийгмийн дунд анги, давхаргын тухай яригдаж буй өнөө үед дунд ангийн амьдралын чанарын үзүүлэлт төр бодлогын анхаарлын төвд байх ёстой. Ихэнх өрхийн орлогын эх үүсвэрийг зонхилон цалин бүрдүүлж байна. Өрхийн орлогод цалин зонхилсон энэхүү “цул” байдлыг задалж, аль болох олон эх үүсвэрээс орлого олдог болгох нь тухайн өрхийн санхүүгийн эмзэг байдлыг багасгах арга зам болно. Түүнчлэн өрхөд эзлэх тэжээгчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Өнөөгийн байдлаар өрхийн нэг тэжээгчид 4 орчим хүн оногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Түүнчлэн залуучуудын хөдөлмөрийн үнэлгээ ялгавартай, цалин орлого харьцангуй бага байна. Суурь судалгааны дүнгээс үзэхэд¹³⁵ өнөөгийн ажил хөдөлмөр эрхэлж буй залуу насны бүлгийн бараг тал хувь(49.9%) нь 500 мянга хүртэлх төгрөгийн орлоготой, залуу өрхийн аль нэг гишүүн ажил эрхлэн(74.5%) амьдарч байна. Гэтэл улсын дундаж болон бодит орлогын хэмжээ залуучуудын цалин, орлогоос 1.5-2 дахин өндөр байгаа юм. 1990 оноос хойшхи хугацаанд хөдөлмөр эрхлэлтэд хөдөө аж ахуй, төр хувийн хэвшил, нийгмийн үйлчилгээний салбар зонхилох шинжтэй байгаагийн зэрэгцээ 2010 оноос хойш уул уурхай, үйлчилгээний салбарт ажиллаж буй хөдөлмөрийн насны тоо хэмжээ өсөн нэмэгдэж байна.

Хүн амын боловсрол, мэдлэгийн түвшин өсөхийн хэрээр хөдөө аж ахуй, газар тариалан, ан агнуурын салбарт хөдөлмөр эрхлэхээс илүүтэй, үйлдвэр үйлчилгээний байгууллагад ажиллах хандлага харагдаж байна. Залуус олноороо суралцаж, дээд боловсролтой хүмүүсийн хувь хэмжээ байнга өсөн нэмэгдэж байгаа энэ үед орлого өндөртэй, тав тухтай орчинд ажиллах хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох нь дамжиггүй. Гэсэн хэдий ч залуу хүмүүст тулгамдаж буй асуудлууд болох цалин бага учир амьдралд нь хүрэлцэхгүй байх(21.3%), боловсрол ахиулсан ч цалинд өөрчлөлт ордоггүй(12.3%), мэргэжилдээ дадлагажаагүй(5.6%), боловсрол мэдлэг дутах(5.5%) явдал хөдөлмөрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж, тэднийг ажлаа хэвийн явуулахад саад болсоор байгаа юм.

Хангалтай цалин орлогогүй, ажлын ачаалал их зэрэг хүчин зүйлс нь хөдөлмөрийн насны хүн амыг ажлаа солих, түр хугацаанд ажилгүй байх, улмаар урт хугацаанд ажил орлогогүй болох, цаашилбал эдийн засгийн хувьд эмзэг байдалд ороход голлох нөлөө үзүүлдэг. Хот хөдөөгөөр харьцуулан залуусын ажилгүйдлийн шалтгааныг авч үзэхэд хөдөөд ажлын байрны хүрэлцээ муу, хотод мэргэжлээрээ ажиллах боломж хомс, хөдөлмөрийн цалин урамшуулал бага, хөдөлмөрийн нөхцөл муу байгаагаас ажилгүйдэлд өртөх, ажилгүйдэх нь их байна.

Хөдөлмөрийн зах зээлд санал болгож буй ажлын байр, түүний нөхцөл, цалин мөнгө ажил хайгчдын сонирхол, эрх ашигт нийцэхгүй байгаагаас, нөгөөтэйгүүр ажиллах хүчний бэлтгэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг мэдрэхгүй байгаагаас тус тус үүдэн ажилгүйдэл бий болж байна.

Улмаар Монголын залуучууд мэргэжлийн болон хүссэн ажил олдохгүй, цалин орлого хангалттай биш байгаагийн улмаас олноор дүрвэн, гадаадад хөдөлмөр эрхлэх, улмаар гэр бүлээсээ хөндийрөх, тусдаа амьдрах, салах зэрэг сөрөг амьдралын хэв маягийг үүсгэж байна. Монголчуудын нийгмийн амьдрал, харилцааг тодорхойлох дараагийн үндсэн хүчин зүйл бол ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой харилцаа, хандлага мөн.

Хүн амын хөдөлмөр эрхлэх идэвхи сул, ажилгүйдлийн түвшин өндөр байна. Дунд болон хижээл насны хүмүүсийн ажилгүйдэлтэй харьцуулахад залуусын ажил эрхлэлтийн түвшин тааруу, ажилгүйдлийн түвшин өндөр бөгөөд идэвхигүй байдлын түвшин ихээхэн өндөр хувьтай байна. Жил бүрийн статистик мэдээг харьцуулан үзвэл Хөдөлмөр эрхлээгүй хүн амын 60-70 хувь нь залуучууд бөгөөд жил тутам 50-60 мянган залуус хөдөлмөрийн насанд шилждэг

¹³⁵НАМЗХ, Социологийн Боловсрол төв. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан. УБ., 2013

боловч тэдгээрийн багадаа 50 хүртэл, ихдээ 60 гаруй хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй үлддэг байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас эрхлэн явуулсан “Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа”-ны үр дүнгээс харахад¹³⁶Залуучуудын ажилгүйдлийн түвшин нийт хүн амын ажилгүйдлийн түвшингээс 2 дахин илүү буюу 14 хувь байгааг уг судалгааны дүн харуулж байна. Тэрчлэн хүн амын бүлгүүд ажилгүй болох үндсэн шалтгаан бол боловсролын байгууллага, институт хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээг харгалзахгүй мэргэжил олгодог, залуучууд хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээгүй мэргэжлийг олноор эзэмших үйл явцтай шууд холбоотой байна. Иймээс ажил мэргэжил судлалыг шинжлэх ухааны түвшин хөгжүүлж, ажил мэргэжлийн чиг баримжааг хүн амын бүлгүүдэд хүртээмжтэй олгох нь зүйтэй байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн болон дээд боловсролын үнэлэмж хандлагын ялгаанаас хамааран эрхэлж буй ажлын нэр хүнд, хөдөлмөрийн үнэлгээний зааг ялгаа их байна. Техник мэргэжлийн сургалт нь хүний хөгжлийн хоёрдогч болон гуравдагч сонголт, харин дээд боловсролтой хүн илүү сайн хөдөлмөр эрхлэх боломжтой, нэр хүндтэй хэмээх алдаатай үзэл хандлага хүн амын дунд зонхилсон хэвээрээ байна. Ялангуяа боловсролын ялгаатай үнэлэмж бүхий эл хандлагыг төрөөс зохицуулж, урамшуулах зорилгоор техник мэргэжлийн боловсрол эзэмшигчдэд тэтгэмж(сарын 45000) олгож байсан боловч дээд боловсрол эзэмшигч оюутнуудад мөн тэтгэмж(сарын 70000) олгох болсноор эл бодлого бүхэлдээ үгүйсгэгдсэн гэж болно. Эдүгээ дээрх алдаатай бодлогыг төрөөс эргэн харж мэргэжлийн сургалтын төвд суралцаж буй оюутнуудын тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч эхэлж байгаа болно.

Цаашид хөдөлмөрийн насны хүн амдажил мэргэжлийн чиг баримжаа олгох, дахин сургах, ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, сургалтын хэрэгцээ илт үгүйлэгдэж байна.Хөдөлмөрийн зах зээлд шинээр дэвшин орж буй хүмүүсийн хувьд бэлэн ажлын байранд шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эхлүүлэх боловсрол мэдлэг, ур чадвар дутмаг байна. Дээд боловсролын чанар тааруу, мэргэжлийн мэдлэг ур чадвар дутмаг, онолын сургалт давамгайлж байгаагаас шалтгаалж, дөнгөж ажил хөдөлмөрийн гараанд гарч буй хүмүүсийн хувьд мэргэжлийн ур чадвар дутах, ажлын байранд гологдох, цалин үнэлэмж доогуур байх зэрэг бэрхшээл тулгарч байгаа болно.

2004 оны Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд ядуу болон нэн ядуу өрхийн хүүхэд, залуусыг мэргэжлийн чиг баримжаа олгох болон ажилд зуучлах үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөсөн боловч үүний хэрэгжилтийн талаар бодитой үнэлгээ, мэдээлэл байхгүй.

Хөдөлмөрийн насны хүн амын хувьд гадаадад хөдөлмөр эрхлэх сэдэл, хандлага түгээмэл хэвээр байна. Албан бус тоогоор 150 мянга орчим Монгол Улсын иргэд хилийн чанадад, өөр улс орнуудад сурч, ажиллаж, амьдарч байгаа нь манай улсын нийт ажиллах хүчний 9.3-18.6 хувийг эзэлж байгаа ажээ. Гадаадад ажиллагсдын дийлэнх нь 20-35 насны бүлэгт хамаарагдаж байгаа ба тэдний дундаж нас 31 байгаа болно. Гадаадад хөдөлмөр эрхлэгчид, тэдгээрийн ар гэрийнхний хувьд тулгамдаж буй томоохон асуудлын нэг бол гэр бүл салалт юм. Ялангуяа БНСУ-д гэрээгээр ажиллагчдын хувьд өндөр үнэтэй байр хөлслөх, түрээслэхдээ хамтран амьдрах, нь түгээмэл бөгөөд удаан хугацаанд хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн ихэнх нь дахин гэрлэсэн буюу гэрлэлтээ цуцлуулсан байв. Түүнчлэн эцэг эхийн халамж, анхаарлаас хол хөндий өсөж буй хүүхдүүдийн нийгмийн асуудал тулгамдсан бөгөөд анхаарвал зохих асуудлын нэг юм. Гадаадад ажиллаж буй залуусын хувьд ихэвчлэн оёдол, барилга, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт, голчлон үнэлгээ багатай “хар бор” гэгдэх туслах, цэвэрлэгээ, үйлчилгээ, хүн асрах, хүүхэд саатуулах, усан онгоц, загас агнуур гм баталгаагүй, эрүүл мэндэд

¹³⁶Франческо Пастор. ОУХБ. Сургуулиас ажилд шилжигсэдийн судалгаа. УБ., 2007

хор хохиролтой нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна. Тухайлбал гадаад улс орон, ялангуяа солонгост ажиллаж байгаа хүмүүсийн хувьд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй, хүнд хортой нөхцөлд ажилладагаас үүдэн олон тооны залуус хөдөлмөрийн чадвар, эрүүл мэнд, амь насаараа хохирсоор байна. Энэ талаар 2010 онд Солонгост буй Монгол Улсын элчин сайд “...Солонгост ажиллаж буй Хүн ам зүйн бүлгүүдийн хувьд 7 хоног бүр 6-7 хүн гэмтэж, 30-40 хүн архидалтаас үүдэн зодоон хийж, тодорхой тооны хүмүүс нас барж байна” хэмээн тэмдэглэсэн нь бий. Гадаадад(Ялангуяа Солонгост) ажил эрхлэгчдийн нас баралтын статистикийг авч үзвэл өнгөрсөн хугацаанд 370 орчим тохиолдол байна.

Эл бүгдэд үндэслэн МУЗГ-аас гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн асуудлыг анхаарч эхэлсний илрэл бол гадаадад ажиллагчдын нийгмийн даатгалын асуудлыг шийдвэрлэсэн явдал байлаа. Түүнчлэн гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучилж буй байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарч эхэлсэн юм. Ер нь МУЗГ гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрлийг тогтолцоот байдлаар, системтэйгээр олгоход шилжилтийн эхнээс дуусах үе хүртэл анхаарч байсангүй. Иймээс ч гадаадад зуучлах албан(Монгол Ньюс, Заг ХХК гм 20 гаруй) болон албан бус(ихэвчлэн хувь хүмүүс) тогтолцоо бий болж, 2004 онд НХХЯ-ны дэргэд “Хөдөлмөр зуучлалын товчоо” байгуулагдан ажиллаж, 15000 мянган ажилчдыг сонгон шалгаруулах кампанит ажил хийж, нас, бие, эрүүл мэндээр шилж сонгон үй олноор нь гадаадад илгээж байлаа. Тухайн үеийн НХХЯ-ны албан тушаалтнууд нутгийн залуусыг гадаадад олноор нь хөдөлмөр эрхлэхээр явуулж байсан мэдээ баримт ч цөөнгүй бий. Үүнээс улбаалан ганц биеэр амьдрагчид нэмэгдэж, залуу насны бүлгийн хувьд ихэвчлэн гэрлээгүй, сурах хүсэл эрмэлзэлтэй хүүхэдгүй бүсгүйчүүд, боловсролтой, ажил төвт¹³⁷, салсан хүмүүс зонхилох болсон юм. Өнөөгийн залуучууд ганц биеэр амьдрах болсны шалтгаан нь а) гэрлэлтийн насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс цөөрсөн(гадаадад хөдөлмөр эрхлэхээр явагсад ихэвчлэн хөдөлмөрийн ид насны хүмүүс байгаа болно), б)залуусын танилцах боломж болсон их дээд сургуульд суралцагчдын (эрэгтэй:30, эмэгтэй:70) хүйсийн харьцаа алдагдсан в) боловсрол хүмүүжлийн түвшингээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоцрогдсон байдал удаан арилж байгаа, г) гэр бүл болох, гэр бүлийн амьдралын бэлтгэл тааруугаас гэр бүл салалтзалуу гэр бүлд их байгаа(гэр бүл цуцлалтын 38 хувь нь 6-7 жил болоод гэр бүлээ цуцлуулсан залуу гэр бүл байна¹³⁸) зэрэг болно.

Эдгээр болон бусад шалтгааны улмаас “гадаадад бус эх орондоо ажиллаж, амьдрах” тухай иргэний нийгмийн дуу хоолой 2008 оноос өрнүүн хэлэлцэгдэх болж ингэснээр МУЗГ гадаадад залуу ажиллах хүч олноор гаргах асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж эхэлсэн. Гадаадад хөдөлмөр эрхэлж буй Хүн ам зүйн бүлгүүдийн дунд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд¹³⁹ тэдний 32.5-47.1 хувь нь гадаад явахаасаа өмнө Монголд ажил эрхэлж байгаагүй нь эдгээр залуусын гадаад улс оронд хөдөлмөр эрхлэх гол шалтгаан бол ажилгүй байсных хэмээн дүгнэхэд хүргэж байна.

МУЗГ-ын 2010 оны 09.28-ны өдрийн 250 тоот тогтоол, Зөгийн үүр хөтөлбөрт “...хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо ирж ажиллах, амьдрахад шаардлагатай бодит мэдээллээр хангах, тэдний боловсрол, мэргэжлийн туршлага, ур чадварын талаар мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх” тухай тусгасан боловч өнөө хэр нь ажил хэрэг болоогүй, бодит үр дүн гараагүй байгаа болно.

Дотоодын шилжинги чанартай хөдөлмөр эрхлэлт залуу гэр бүлд хохирол учруулсаар байна. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтэд гарч буй нэгэн өөрчлөлт бол гэрээс хол, тодорхой хугацаагаар тусгаарлагдсан нөхцөлд хөдөлмөр эрхлэх байдал нэмэгдсэн явдал болно. 2010-2015 онд хөдөлмөрийн зах зээл дээр нийт 40000 гаруй ажлын байр шинээр бий болохоос 6000 гаруй инженер техникийн ажилтан шаардлагатай байгаа ба өндөр технологийн аж үйлдвэрийн

¹³⁷Б.Даш-Ёндон нар. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. Х.208. УБ., 2009.

¹³⁸НҮБХАС. НХХЯ. ФСЭЗХ. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Социологийн судалгааны тайлан. Х.57. УБ., 2010

¹³⁹МУЗГ. НХХЯ. Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар. Судалгааны тайлан. УБ., 2005

салбарт шинээр ажиллах хүчний эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр зэрэг аймгуудад олборлох үйлдвэр, уул уурхайн компаниуд олноор бий болж, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнийг үүсгэж байгаа болно. Ингэснээр Монголчууд 14, 28 хоногоор ажиллаж амрах болсноор гэр бүлээс хөндийрөх, тусдаа амьдрах, улмаар гэр бүл салах хүртэл сөрөг нөлөө үзүүлэх болсон.

Нөгөөтэйгүүр дотоодод нас, мэргэжил, хүйсийн онцлогоос хамааран хөдөлмөрийн хөлсний ялгаа үлэмж их, хүнд, хортой нөхцлүүд байсаар байна. Ялангуяа барилга болон уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлаас үүдэлтэй аваар осол ихээр гарах болж, хүн амын дунд золгүй, тохиолдлын шинжтэй нас баралт ихсэх болсон. Уул уурхай, барилга зэрэг ажлын байран дахь аюулгүй байдлын сургалт дадал, техник тоног төхөөрөмж, ажлын орчин хангалтгүйгээс хөдөлмөрийн осол гэмтэл зонхилон гарч байна. Өөрчлөгдөн буй өнөөгийн эрин цагт, Монгол хүн ажиллаж, хөдөлмөрлөж түүнийхээ амт шимтийг мэдрэх, нөгөөтэйгүүр эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэж, урт удаан аз жаргалтай амьдрах хандлагыг эрхэмлэх болсон нь амьдралын чанарт гарч буй томоохон дэвшил мөн.

Монголчуудын амьдралын чанарт нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар онцгой нөлөөтэй юм. Монгол Улсын хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин дан ганц зах зээлийн ардчилсан шилжилтийн үр дүн хараахан биш юм. Социалист нийгмийн үед хүний хөгжил, сайн сайхан байдалд олон талын ахиц гарсан юм. Тухайн үеийн улсын төсвийн бараг 40 хувь нь дангаараа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээнд зарцуулагддаг байжээ. Зах зээлд шилжихийн өмнөх Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоо нь зөвлөлтийн “Семашко” загварт суурилж байсан бөгөөд улсын төсвөөс бүтэн санхүүждэг байжээ. Энэ загвар нь хангалттай санхүүжилтгүй бол хүн ам таруу суурьшсан улс оронд хэрэгжүүлэхэд зохимжтой биш гэдгийг Азийн хөгжлийн банкны экспертүүд дурьдсан нь бий. Үүний үр дүнд эрт нас баралт багасч, дундаж наслалт нэмэгдэн, бичиг үсэг үл мэдэх явдал бараг арилсан. 1990-ээд оны эхэн үеийн хямралаас үүдэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зардал хумигдсанаар хүн амын амьдралын чанарт сөргөөр нөлөөлсөн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртгийг багасгах талаар нэлээд алхамууд хийгдэж байгаа хэдий ч дунд болон бага орлоготой хүмүүсийн бүлэг эрүүл мэнддээ орлогын ихэнх хэсгийг зарцуулж байна. Жишээ нь 1998 онд хийгдсэн амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар эм, эмнэлгийн тусламжинд ядуу өрхүүд нийт зардлын 3 хувь, ядуу бус өрхүүд 2 хувийг зарцуулдаг болохыг тогтоосон. Бидний судалгаагаар амьдралын чанар муудаж, ядууралд өртөхийн эхний шалтгаан нь эдийн засгийн хүчин зүйл болох амьжиргааны байдал-орлогын хүрэлцээ, харин хоёр дахь гол шалтгаан нь өвчлөх явдал байдаг гэсэн дүн гарчээ. Ядуурал болон эрүүл мэндийн дорой байдал нь амьдралын нөхцөл муу, тааруу байхтай шууд холбоотой байна. Ядуу хүмүүс ихэвчлэн гэрт амьдардаг бөгөөд гэр сууц нь зарим талаар эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, Улаанбаатар хотын захын гэр хороололд хийсэн судалгаагаар гэрийн халаалтын арга ба хүүхдийн амьсгалын замын халдварын хооронд шууд хамаарал байгааг тогтоожээ. Ядуу хүмүүс ихэвчлэн эрүүл ахуйн шаардлагад тохирохгүй, зохимжгүй аргаар гэрээ халаадаг. Энэ нь гэрт амьдардаг бие султай өндөр настан төдийгүй өвчин эмгэгтэй аль ч насны хүмүүсийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна.

Судалгааны дүн, баримт бичиг, статистик мэдээллээс шүүн үзэхэд хүн ам, өрх гэрийн амьжиргаа, амин зуулга, орлого, хөдөлмөр эрхлэлт, сууцны нөхцөл, гэрлэлт, шилжих хөдөлгөөн, нийгмийн статус-зэрэг дэвийн шилжилт, үнэлэмж хандлага, чөлөөт цагаа өнгөрөөх хэлбэр хэв маяг олон талаар, үлэмж өөрчлөгдсөн байна. Гагцхүү эдгээрийг цогц хэлбэрээр, системтэйгээр авч үзэж, тулгамдаж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хүнийг хөгжүүлэх, орчныг хамгаалахад Хүн амын амьдралын чанарыг хангах үзэл баримтлал төр, засгийн бодлогын төвд тавигдах учиртай.

▪ **Хууль эрхийн хүрээнд**

Монгол Улсын хууль тогтоомжууд хүн ам, иргэний нийтлэг харилцааг зохицуулж буйн хувьд амьдралын чанарын судалгаанд харгалзвал зохих, шинжилгээний суурь үзүүлэлт билээ. Энэ хэсэгт өнгөрсөн хугацаанд батлагдсан хууль, эрх зүйн орчинд гарсан гол гол шинэтгэлүүдийн

талаар товч авч үзсэн. Тухайн улсын хууль, эрхийн орчныг авч үзэхдээ үндсэн хууль, тулгуур хууль, тогтоомж болон хууль эрхийн акт, баримт бичгүүдийг авч үздэг. Юуны өмнө шилжилтийн эхэнд Монгол Улсын шинэ үндсэн хуулийг баталж, хүмүүнлэг, иргэнлэг, ардчилсан нийгмийн суурь зарчмуудыг тодорхойлсон явдал хууль эрхийн орчны үндсэн өөрчлөлтийн нэг байв. Нийгэм, эдийн засаг, улс төрийн шилжилтийн 20 гаруй жилийн хугацаанд хүн амын насны бүлгүүдийн эрх, үүрэг, амьдрах орчин, үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн олон тооны хууль, тогтоомж батлагдсан байна. Энэ хугацаанд зөвхөн хүүхдийн эрх үүрэг, гэр бүлийн харилцааг зохицуулах талаар 330 гаруй хууль, дүрэм журмыг шинээр болон шинэчлэн баталж хэрэгжүүлжээ. Залуучууд, хижээл насны болон ахмад настан тэдгээрийн тэтгэмж, хангамж, харилцааг зохицуулах 500 гаруй төрлийн эрх зүйн акт, хууль, дүрэм журам батлагджээ. Байгаль, орчныг хамгаалах, нөхөн сэргээх урт нэртэй хууль батлагдсаны дээр, хүн амын амьдрах орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээнд нэгдэж, 10 орчим хөтөлбөрийг баталсан юм. Авлига, хээл хахууль, өндөр түвшний авлигатай бүх түвшинд, хуулийн дагуу тэмцэх, авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх нь ард иргэдийн ирээдүйд итгэх итгэл, сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлөх болно. Эл чиглэлд хөрш хоёр улсын практикаас жишээ авч, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих болсон нь хүн амын төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болохыг үгүйсгэхгүй.

Хүн амын амьдралын чанарын шинжилгээнээс үзэхэд Монгол Улсын төр засгийн бодлого, үйл ажиллагаа ирээдүйгээс ямагт хоцорсон, нэгэнт болох үйл явдлыг угтаж хараагүй, үзэгдэл үйл явцыг болоод өнгөрсний дараа авч хэрэгжүүлэх байдлаар, шинжлэх ухаанаас ангид явж иржээ. Иймээс ч “Урьдчилан харахын тулд мэд” хэмээсэн социологийг үндэслэгч, сэтгэгч О.Контыноноч мэргэн үгийг энд дурдах нь зүйн хэрэг билээ.

Дүгнэлтийн оронд

Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх нь Мянганы хөгжлийн нэгдүгээр зорилт, төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын хувьд тулгамдсан бөгөөд хойшлуулшгүй чухал асуудлын нэг байсаар байна, цаашид ч байх болно.

- Судалгааны үр дүнгээс үзэхэд амьдралын чанарыг дээшлүүлэх асуудал бол шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой бодлого, үр нөлөө бүхий урт хугацааны, шаргуу үйл ажиллагаанаас шууд хамаарах бөгөөд Монгол Улсын хувьд нийгмийн бүлгүүдэд чиглэсэн амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого хомс байсаар өнөөг хүрчээ.
- Амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр Скандинавын болон Европын улс орнууд ихээхэн амжилт олсон бөгөөд хүн ам наад захын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ орон сууц гм оршин суух тав тух, түүнчлэн нийгмийн үйлчилгээнээс хүртэх алслалт, зай зэргийг хүртэл амьдралын чанарын хэмжих үзүүлэлт болгож байгаа нь анхаарал татаж байна. Улс орон бүр хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх талаар өөрийн онцлог, түүхэн туршлагатай. Хөрш улсуудын хувьд ч хүн амын амьдралын чанарыг хангах үйл явцыг төрийн бодлогын төвд тавьж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс хөгжингүй болон хөгжлийн хувьд ойролцоо улс орнуудын туршлагыг сайтар судлан, өөрийн орны нөхцөлд тохирох хувилбар боловсруулж хэрэгжүүлэх нь цаг үеэ олсон чухал зүйл мөн
- Өнөөгийн нийгмийн хөгжлийн үзэл баримтлалаар “хөдөлмөр эрхлэх эсэх нь хувь хүний сонголтын асуудал” боловч “ажил хөдөлмөрт хайнга хандахгүйгээр, ажилсаг бүтээлч байсны дүнд улс орон хөгждөг” болохыг энгийн иргэнээс төрийн бодлого боловсруулагч хүртэл сэхээрэх цаг хэдийнээ болсон байна. Дээрх үйл явц халамжаас хөдөлмөрт шилжих төрийн бодлогын хэрэгжилттэй уялдах, басхүү нөхөн гүйцээх учиртай.
- Хүн амын амьдралын чанарыг хангах тухай бодлого, эдийн засаг, нийгэм, орчны шинжилгээнээс үзэхэд Монгол Улсын төр засгийн бодлого, үйл ажиллагаа ирээдүйгээс ямагт хоцорсон, нэгэнт болох үйл явдлыг угтаж хараагүй, үзэгдэл, үйл явдал болоод өнгөрсний дараа авч хэрэгжүүлэх байдлаар явж иржээ. Уг шинжилгээнээс үзэхэд, нэн

тэргүүнд хүн амын насны бүлэг тус бүрийн онцлог, хэрэгцээг тусгасан амьдралын чанарыг сайжруулах, дэмжих төрийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна. Ингэхийн тулд хүн амын амьдралын чанарыг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хүрээнд бүх түвшиндхангах хууль эрхийн орчинг бий болгох/зөвхөн хөгжлийн хөтөлбөр бодлогод тунхаг байдлаар тусгалгүйгээр/, нэгэнт батлагдсан хуульд нэмж тусгаж өгөх шаардлагатай. Тухайлбал, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд хүүхдэд үзүүлэх нийгэм, экологийн орчны нөлөөллийн стандартыг тусгайлан тусгаж өгөх, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд ахмадын амьдралын чанарын байвал зохих стандартыг тусгах, залуучуудын эмзэг байдлыг бууруулах, дэмжих талаар нийгмийн хамгааллын хууль тогтоомжид багц хэлбэрээр тусгах, шинээр хууль батлах хэрэгцээ шаардлага зайлшгүй бий. Хүн амын аюулгүй, амар тайван амьдрах бүхий л тал нөхцлийг хангасан хуулийг батлан хэрэгжүүлэхийн дээр одоогийн нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг ирээдүйн чиг хандлагад нийцүүлэх нь зүй ёсны хэрэг юм.

- Энэхүү судалгааны ажлын хүрээнд дурьдсан дүгнэлт, зөвлөмж нийгмийн хөгжилтэй уялдан, цаг хугацааны хувьд нарийвчлагдан, хувирч өөрчлөгдөхийг үгүйсгэхгүй бөгөөд цаашид хийх судалгааны үндэс суурь болж өгөх нь лавтай.

Summary

There are lot of changes in livelihood and its surrounding environment, attitude, immediate challenges and demand of people those are living in open market system after social and economic transmission. These comprehensive changes are ongoing at individual level to family, group to community and further society to the environment. The key concept to describe the growth and social progress is quality of living. Countries in modern world tend to express their social and economic growth by the growth of quality of life of their population. Present status of social growth depends on social security, welfare, level of consumption and satisfaction of population of the country. Quality of life index becomes main indicator for the development of the country as well as main indicator to compare growth level among the countries.

Thus scientifically based evaluation is in great demand to compare changes emerged in quality of living of Mongolians in market society with other indexes for quality of living among different countries as referred to relevant studies and methodologies. Government policy and actions were always delayed when it is needed and there is gap of vision and assumptions for possible events in the future as we analyze existing policies to ensure quality of living for population and relevant social and economic studies. There is great demand of policy to support and improve quality of living for population as reflecting particularity and demand of each age group of population we concluded by this study.

Key term; quality of life, government policy

Ашигласан ном зохиол

1. МУЗГ.Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2006 оны 282-р тогтоол. УБ.,2006
2. МУЗГ. НХХЯ. “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлан УБ., 2007.
3. УИХ.Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого. УИХ-ын 1996 оны 22-р тогтоол. УБ., 1996.
4. УИХ.Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. 3-р зүйл. УБ. УИХ. 1996, 2015.
5. Бестужев-Лада.И.В. Методологические проблемы исследования качества, уровня и образа жизни. Москва: ИСИ АН., 1978
6. Давыдова.Е.В.,Давыдов А.А.(1993).Измерениякачестважизни. М.Наука., 1993.Бобкова.В. Качество и уровень жизни населения в новой России (1991-2006 гг.). Москва: ВЦУЖ 2007
7. Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар. XXI зууны босгон дахь Монголын залуучууд.. Адмон хэвлэл. УБ., 2000.
8. Даш-Ёндон. Б Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013
9. Маркс.К., Энгельс.Ф. Түүвэр зохиол, 3 боть. Улаанбаатар. УХГ. УБ., 1982
10. М.Батбаатар. Залуучуудын амьдралын чанарт нөлөөлж буй нийгмийн асуудлууд: төлөв байдал, чиг хандлага. Нийгмийн ажил сэтгүүл. №4, X.9. МУИС.УБ., 2010.
11. М.Батбаатар болон бусад. Хот хөдөөгийн шилжих хөдөлгөөн ба хүүхдийн боловсролын хүртээмж. АХИС, ХЯБСТ. УБ., 2005.
12. Монголын Залуучуудын хөгжлийн хэрэгцээ: суурь судалгааны тайлан. МЗХ-ны Полиси төв УБ., 2002-2003.
13. Монгол Улсын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Азийн хөгжлийн банк, “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”судалгааны тайлан. УБ., 2010.
14. НАМЗХ, Социологийн Боловсрол төв. Залуучуудын талаар баримтлах төрийн бодлого: суурь судалгааны урьдчилсан тайлан. УБ., 2013.
15. Осипов.Г.В. Социология и социализм. М:Наука. 1990
16. Оюут-эрдэнэ. Н болон бусад. Ахмад настнуудын амьдралын чанарт үзүүлэх тэтгэвэрийн үр нөлөө. НАБСХ.УБ., 2007.
17. Смелзер. Н.Социологи. Улаанбаатар: Адмон хэвлэл. УБ., 2000
18. Г.Түмэннаст болон бусад. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээний өнөөгийн байдал. Судалгааны тайлан. ЯХИС.УБ., 2015.
19. ҮСХ.Хүн ам, орон сууцны тооллого, Монголын ахмад насны хүн ам. УБ., 2000.
20. ҮСХ, АХБ, Дэлхийн банк. Оролцооны аргаар ядуурлыг үнэлэх судалгаа. УБ., 2006.
21. ҮСГ. НХХЯ, НҮБ-ын Хүн амын сан. Ахмад настны ахуйн нөхцлийн түүвэр судалгаа. УБ., 2001.
22. ҮСГ.Өрхийн орлого зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа.УБ., 2003.
23. Үндэсний статистикийн газар, Азийн хөгжлийн банк: Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003, УБ., 2004.
24. Франческо Пастор. ОУХБ. Сургуулиас ажилд шилжигсэдийн судалгаа. УБ., 2007
25. UNO. International definition and measurement of standards and levels of living, NY., 1961
26. <http://mongol.cri.cn/343/2011/03/04/61s150656.htm>.
27. <http://mongolian.ruvr.ru>